

**ХУУЛЬ ЗҮЙН БАЙНГЫН ХОРООНЫ
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА
2024 оны 06 дугаар сарын 04-ний өдөр, Мягмар гараг**

<i>Хуралдааны тэмдэглэлийн агуулга</i>	
<i>Хуралдааны товч тэмдэглэл:</i>	1-7
<i>Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:</i>	8-45
<hr/>	
<i>1.Монгол Улсын шүүхийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Улсын Их Хурлын гишүүн Д.Цогтбаатар нарын 4 гишүүн 2024.05.17-ны өдөр өргөн мэдүүлсэн, эцсийн хэлэлцүүлэг/</i>	10-14
<i>2.Монгол Улсын шүүхийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдтэй холбогдуулан боловсруулсан Монгол Улсын шүүхийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн төсөл /анхны хэлэлцүүлэг/</i>	14-22
<i>3.Монгол Улсын дээд шүүх, Шүүхийн ерөнхий зөвлөл, Шүүхийн сахилгын хороо болон Хүний эрхийн Үндэсний комиссын 2025 оны төсвийн төсөл</i>	22-45
<hr/>	

**Монгол Улсын Их Хурлын 2024 оны хаврын ээлжит чуулганы
Хууль зүйн байнгын хорооны 06 дугаар сарын 04-ний өдөр
/Мягмар гараг/-ийн хуралдааны товч тэмдэглэл**

Улсын Их Хурлын гишүүн Б.Энх-Амгалан ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 19 гишүүнээс 10 гишүүн хүрэлцэн ирж, 52.6 хувийн ирцтэйгээр хуралдаан 15 цаг 14 минутад Төрийн ордны “Жанжин Д.Сүхбаатар” танхимд эхлэв.

Томилолттой: Н.Алтанхуяг, С.Бямбацогт, Д.Ганбат, Б.Дэлгэрсайхан;
Чөлөөтэй: Л.Мөнхбаатар, Ц.Мөнх-Оргил, Б.Пүрэвдорж;
Эмнэлгийн чөлөөтэй: Г.Амартүвшин.

Хэлэлцэх асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Ш.Адъяаагийн тавьсан асуултад Улсын Их Хурлын гишүүн Б.Энх-Амгалан хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн Б.Энх-Амгалан хэлэлцэх асуудлын дарааллын 4 дэх асуудал болох Байнгын хорооны тогтоолын төслийг /Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг хэлэлцүүлэгт бэлтгэх үүрэг бүхий ажлын хэсэг байгуулах тухай/ хэлэлцэхийг хойшлуулах горимын санал гаргав.

Б.Энх-Амгалан: Горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 8

Татгалзсан: 2

Бүгд: 10

80.0 хувийн саналаар горимын санал дэмжигдсэн тул уг асуудлыг хэлэлцэхийг хойшлуулав.

Нэг.Монгол Улсын шүүхийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Улсын Их Хурлын гишүүн Д.Цогтбаатар нарын 4 гишүүн 2024.05.17-ны өдөр өргөн мэдүүлсэн, эцсийн хэлэлцүүлэг/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Хууль зүй, дотоод хэргийн сайд Б.Энхбаяр, Шүүхийн ерөнхий зөвлөлийн дарга Л.Энхбилэг, мөн зөвлөлийн гишүүн Н.Баасанжав, Н.Мөнгөнцэцэг, Хуулийн хэлтсийн дарга Б.Оюунгэрэл, Шүүхийн сахилгын хорооны дарга Ц.Давхарбаяр, Улсын дээд шүүхийн Тамгын газрын дарга С.Заяадэлгэр, мөн шүүхийн Шүүхийн сургалт, судалгаа, мэдээллийн хүрээлэнгийн захирал Д.Эрдэнэчимэг нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх П.Хулан, Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Хууль зүйн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Г.Золжаргал, референт Б.Галсанбат, мөн хэлтсийн ахлах мэргэжилтэн Д.Дөлгөөн нар байлцав.

Төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх ажлын хэсгийн танилцуулгыг ажлын хэсгийн ахлагч, Улсын Их Хурлын гишүүн Ц.Сандаг-Очир танилцуулав.

Танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Ц.Сэргэлэн, Ш.Адъяа нар үг хэлэв.

Байнгын хорооны дарга Д.Цогтбаатар 15 цаг 28 минутаас хуралдааныг даргалав.

Байнгын хорооны дарга Д.Цогтбаатар Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.2.3-г заасны дагуу санал хураалгах горимын санал гаргав.

Д.Цогтбаатар: Байнгын хорооны дарга Д.Цогтбаатарын гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 7
Татгалзсан: 4
Бүгд: 11
Гуравны хоёроор дахин санал хураалгах санал дэмжигдлээ.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.2.3-т нэгдсэн хуралдааны анхны хэлэлцүүлгээр санал хурааж дэмжигдсэн боловч уг саналаар Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн гуравны хоёроос доошгүй нь дахин санал хураалгах шаардлагатай гэж үзсэний дагуу санал хураалт явуулав.

1.Монгол Улсын шүүхийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар:

Д.Цогтбаатар: 1.Төсөлд доор дурдсан агуулгатай 5 дугаар зүйл нэмэх:

“5 дугаар зүйл.Монгол Улсын шүүхийн тухай хуулийн 72 дугаар зүйлийн 72.1.6 дахь заалтын “шүүгч болон” гэснийг хассугай.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 8
Татгалзсан: 3
Бүгд: 11
Гуравны хоёроор санал дэмжигдлээ.

Улсын Их Хурлын гишүүн Д.Цогтбаатарын “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул санал хураалтын дүнг дэмжсэнээр протоколд тэмдэглүүлэх санал гаргаж, дэмжсэнээр тооцов.

Нийт 11 гишүүнээс 9 гишүүн дэмжиж, гуравны хоёроор санал дэмжигдлээ.

2.Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар:

Д.Цогтбаатар: 1.Төслийн 3 дугаар зүйлийн 9 дүгээр зүйлийн 9.2.2 дахь заалтын “үндсэн эрхэд” гэснийг “амь нас, эрүүл мэндэд” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 7
Татгалзсан: 4
Бүгд: 11
Гуравны хоёроор санал дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын гишүүн Д.Цогтбаатарын “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас эсрэг гарсан тул дээрх санал хураалтыг хүчингүй болгож, дахин санал хураалт явуулах горимын санал гаргав.

Д.Цогтбаатар: Улсын Их Хурлын гишүүн Д.Цогтбаатарын гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 7
Татгалзсан: 4
Бүгд: 11
63.6 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

Д.Цогтбаатар: 1.Төслийн 3 дугаар зүйлийн 9 дүгээр зүйлийн 9.2.2 дахь заалтын “үндсэн эрхэд” гэснийг “амь нас, эрүүл мэндэд” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалтыг дахин явуулъя.

Зөвшөөрсөн: 10
Татгалзсан: 2
Бүгд: 12
Гуравны хоёроор санал дэмжигдлээ

Байнгын хорооноос гарах танилцуулгыг Улсын Их Хурлын гишүүн Ш.Раднаасэд Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 15 цаг 39 минутад хэлэлцэж дуусав

Хоёр.Монгол Улсын шүүхийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдтэй холбогдуулан боловсруулсан Монгол Улсын шүүхийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн төсөл /анхны хэлэлцүүлэг/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Хууль зүй, дотоод хэргийн сайд Б.Энхбаяр, Шүүхийн ерөнхий зөвлөлийн дарга Л.Энхбилэг, мөн зөвлөлийн гишүүн Н.Баасанжав, Н.Мөнгөнцэцэг, Хуулийн хэлтсийн дарга Б.Оюунгэрэл, Шүүхийн сахилгын хорооны дарга Ц.Давхарбаяр, Улсын дээд шүүхийн Тамгын газрын дарга С.Заяадэлгэр, мөн шүүхийн Шүүхийн сургалт, судалгаа, мэдээллийн хүрээлэнгийн захирал Д.Эрдэнэчимэг нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх П.Хулан, Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Хууль зүйн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Г.Золжаргал, референт Б.Галсанбат, мөн хэлтсийн ахлах мэргэжилтэн Д.Дөлгөөн нар байлцав.

Хуулийн төслийг анхны хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх ажлын хэсгийн санал, дүгнэлтийг ажлын хэсгийн ахлагч, Улсын Их Хурлын гишүүн Ц.Сандаг-Очир танилцуулав.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.10-т заасны дагуу Монгол Улсын шүүхийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдтэй холбогдуулан боловсруулсан Монгол Улсын шүүхийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэв.

Төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Ж.Сүхбаатар, Д.Ганбат нар тавьсан асуултад Шүүхийн ерөнхий зөвлөлийн дарга Л.Энхбилэг, Улсын дээд шүүхийн Тамгын газрын дарга С.Заяадэлгэр, хууль санаачлагч, Улсын Их Хурлын гишүүн Д.Цогтбаатар нар хариулж, тайлбар хийв.

Төслийн 2 дугаар зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Д.Цогтбаатар: 1.Төслийн 1 дүгээр зүйлийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 6
Татгалзсан: 4
Бүгд: 10
60.0 хувийн саналаар дэмжигдлээ.

Улсын Их Хурлын гишүүн Д.Цогтбаатарын “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул санал хураалтын дүнг дэмжсэнээр протоколд тэмдэглүүлэх санал гаргаж, дэмжсэнээр тооцов.

Нийт 10 гишүүнээс 7 гишүүн дэмжиж, 70.0 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Төслийн 2 дугаар зүйлийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 7
Татгалзсан: 3
Бүгд: 10
70.0 хувийн саналаар дэмжигдлээ.

Улсын Их Хурлын гишүүн Д.Цогтбаатар Монгол Улсын шүүхийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдтэй холбогдуулан боловсруулсан Монгол Улсын шүүхийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн төслийн анхны

хэлэлцүүлгийг эцэслэн батлах үе шаттай нэгтгэн явуулах саналыг нэгдсэн хуралдаанд гаргах нь зүйтэй гэсэн горимын санал гаргав.

Д.Цогтбаатар: Улсын Их Хурлын гишүүн Д.Цогтбаатарын гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 8
Татгалзсан: 2
Бүгд: 10
80.0 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Ц.Сандаг-Очир Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 16 цаг 09 минутад хэлэлцэж дуусав.

Гурав.Монгол Улсын дээд шүүх, Шүүхийн ерөнхий зөвлөл, Шүүхийн сахилгын хороо болон Хүний эрхийн Үндэсний комиссын 2025 оны төсвийн төсөл

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Монгол Улсын дээд шүүхийн Тамгын газрын дарга С.Заяадэлгэр, мөн шүүхийн Шүүхийн сургалт, судалгаа, мэдээллийн хүрээлэнгийн захирал Д.Эрдэнэчимэг, Ерөнхий нягтлан бодлогч А.Эрдэнэцэцэг, Шүүхийн ерөнхий зөвлөлийн дарга Л.Энхбилэг, мөн зөвлөлийн гүйцэтгэх нарийн бичгийн дарга Б.Эрдэнэтулга, Санхүү, хөрөнгө оруулалтын газрын дарга С.Наранбилэг, гишүүн Н.Мөнгөнцэцэг, Шүүхийн сахилгын хорооны дарга Ц.Давхарбаяр, мөн хорооны Ажлын албаны дарга Д.Мөнхзориг, Ерөнхий нягтлан бодогч Б.Ариунжаргал, Хүний эрхийн Үндэсний Комиссын дарга Д.Сүнжид, мөн комиссын Тамгын газрын дарга Ц.Адъяахишиг, нягтлан бодогч Б.Бадамсэрээжид нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх Г.Алтанцэцэг, мөн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Хууль зүйн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Г.Золжаргал, Хяналт шалгалт, үнэлгээний газрын Төсвийн хяналт, шинжилгээний хэлтсийн дарга Д.Эрдэнэсамбуу, референт Ш.Батцэнгэл, Ц.Отгонбаатар, Д.Гэрэлт-Од, Ч.Сарантуяа нар байлцав.

Монгол Улсын дээд шүүхийн 2025 оны төсвийн төслийн талаар:

Монгол Улсын дээд шүүхийн 2025 оны төсвийн төслийн талаарх танилцуулгыг Монгол Улсын дээд шүүхийн Тамгын газрын дарга С.Заяадэлгэр танилцуулав.

Танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Ж.Сүхбаатар, Б.Энх-Амгалан нарын тавьсан асуултад Улсын дээд шүүхийн Тамгын газрын дарга С.Заяадэлгэр хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн Б.Энхбаяр үг хэлэв.

Д.Цогтбаатар: Улсын дээд шүүхийн 2025 оны төсвийн саналыг хасагдуулахгүйгээр Төсвийн ерөнхийлөн захирагчид хүргүүлэхийг дэмжье гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 6
Татгалзсан: 5
Бүгд: 11
54.5 хувийн саналаар дэмжигдлээ.

Хүний эрхийн Үндэсний комиссын 2025 оны төсвийн төслийн талаар:

Хүний эрхийн Үндэсний комиссын 2025 оны төсвийн төслийн талаарх танилцуулгыг Хүний эрхийн Үндэсний Комиссын дарга Д.Сүнжид танилцуулав.

Танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Ц.Мөнхцэцэг, Ж.Сүхбаатар нарын тавьсан асуултад Хүний эрхийн Үндэсний Комиссын дарга Д.Сүнжид, мөн комиссын Тамгын газрын дарга Ц.Адъяахишиг нар хариулж, тайлбар хийв.

Д.Цогтбаатар: Хүний эрхийн Үндэсний Комиссын 2025 оны төсвийн төслийн саналыг бууруулахгүйгээр Төсвийн ерөнхийлөн захирагчид хүргүүлэхийг дэмжье гэсэн санал хураалт явууля.

Зөвшөөрсөн: 6
Татгалзсан: 5
Бүгд: 11
54.5 хувийн саналаар дэмжигдлээ.

Шүүхийн ерөнхий зөвлөлийн 2025 оны төсвийн төслийн талаар:

Шүүхийн ерөнхий зөвлөлийн 2025 оны төсвийн төслийн талаарх танилцуулгыг Шүүхийн ерөнхий зөвлөлийн дарга Л.Энхбилэг танилцуулав.

Танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Ж.Сүхбаатар, Б.Энхбаяр, Б.Энх-Амгалан нарын тавьсан асуултад Шүүхийн ерөнхий зөвлөлийн дарга Л.Энхбилэг, мөн зөвлөлийн гүйцэтгэх нарийн бичгийн дарга Б.Эрдэнэтулга нар хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн Б.Энх-Амгалан үг хэлэв.

Д.Цогтбаатар: Шүүхийн ерөнхий зөвлөлийн 2025 оны төсвийн төслийн саналыг бууруулахгүйгээр төсвийн ерөнхийлөн захирагчид хүргүүлэхийг дэмжье гэсэн санал хураалт явууля.

Зөвшөөрсөн: 6
Татгалзсан: 5
Бүгд: 11
54.5 хувийн саналаар дэмжигдлээ.

Шүүхийн сахилгын хорооны 2025 оны төсвийн төслийн талаар:

Байнгын хорооны дарга Д.Цогтбаатар Шүүхийн сахилгын хорооны 2025 оны төсвийн төслийн талаарх танилцуулгыг Улсын Их Хурлын гишүүдэд тараасан байгааг мэдэгдэв.

Танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Д.Цогтбаатар: Шүүхийн сахилгын хорооны 2025 оны төсвийн төслийн саналыг бууруулахгүйгээр төсвийн ерөнхийлөн захирагчид хүргүүлэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 6
Татгалзсан: 5
Бүгд: 11
54.5 хувийн саналаар дэмжигдлээ.

Уг асуудлыг 17 цаг 38 минутад хэлэлцэж дуусав.

Байнгын хорооны хуралдаанаар 3 асуудал хэлэлцэв.

Хуралдаан 2 цаг 24 минут үргэлжилж, 19 гишүүнээс 11 гишүүн хүрэлцэн ирж, 57.9 хувийн ирцтэйгээр 17 цаг 38 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:
ХУУЛЬ ЗҮЙН БАЙНГЫН ХОРООНЫ
ДАРГА

Д.ЦОГТБААТАР

Тэмдэглэл хөтөлсөн:
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ
ХӨТЛӨХ АЛБАНЫ
ШИНЖЭЭЧ

Д.ОТГОНДЭЛГЭР

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2024 оны 06 дугаар сарын 04-ний өдөр,
Мягмар гараг
Төрийн ордон “Жанжин Д.Сүхбаатар”
танхим
15 цаг 14 минут.

ХУУЛЬ ЗҮЙН БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

Б.Энх-Амгалан: Байнгын хорооны эрхэм гишүүдийн энэ өдрийн амар амгаланг айлтгая.

Байнгын хорооны гишүүдийн их олонх хүрэлцэн ирсэн тул Хууль зүйн байнгын хорооны 2024 оны 6 сарын 4-ний өдрийн хуралдааныг нээснийг мэдэгдье.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 11.6-д заасны дагуу ирцийг танилцуулъя.

Дамдины Цогтбаатар ирж байна. Ширнэнбаньдийн Адышаа гишүүн ирсэн байна. Ганибалын Амартүвшин гишүүн өвчтэй байна. Норовын Алтанхуяг гишүүн чөлөөтэй байна. Энхтайваны Бат-Амгалан гишүүн ирсэн байна. Сандагийн Бямбацогт гишүүн орон нутгийн томилолттой байна. Дашидондогийн Ганбат гишүүн чөлөөтэй байна. Борхүүгийн Дэлгэрсайхан гишүүн хөдөө орон нутагт томилолттой байна. Лхагвын Мөнхбаатар гишүүн орон нутагт томилолттой байна. Цэндийн Мөнх-Оргил гишүүн чөлөөтэй байна. Цэрэнжамцын Мөнхцэцэг гишүүн ирсэн байна. Бөхчулууны Пүрэвдорж гишүүн орон нутагт томилолттой байна. Шатарбалын Раднаасэд гишүүн ирсэн байна. Цэндийн Сандаг-Очир гишүүн ирсэн байна. Жамъянхорлоогийн Сүхбаатар гишүүн ирсэн байна. Цэдэвийн Сэргэлэн гишүүн ирсэн байна. Ням-Осорын Учрал гишүүн ирсэн байна. Баттөмөрийн Энхбаяр гишүүн ирсэн

байна. Бямбасүрэнгийн Энх-Амгалан гишүүн ирсэн байна. Ингээд гишүүдийн ирцийг танилцуулж дууслаа. Өнөөдрийн Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх асуудлыг танилцуулъя та бүхэнд.

Нэгдүгээрт, Монгол Улсын шүүхийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд, Улсын Их Хурлын гишүүн Д.Цогтбаатар нарын 4 гишүүн 2024 оны 5 сарын 17-ны өдөр өргөн мэдүүлсэн эцсийн хэлэлцүүлэг.

2.Монгол Улсын шүүхийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдтэй холбогдуулан боловсруулсан Монгол Улсын шүүхийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн төсөл анхны хэлэлцүүлэг.

3.Улсын дээд шүүх, Шүүхийн ерөнхий зөвлөл, Шүүхийн сахилгын хороо болон, Хүний эрхийн Үндэсний Комиссын 2025 оны төсвийн төсөл.

4.Байнгын хорооны тогтоолын төсөл. Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг Байнгын хорооны болон чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх бэлтгэл хангах санал, дүгнэлтийн төсөл боловсруулах үүрэг бүхий ажлын хэсэг байгуулах. Ийм 4 асуудлыг хэлэлцэхээр байна.

Хэлэлцэх асуудал, бас нэг горимын санал байгаа юм байна. Тэр нь болохоор зэрэг Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн ажлын хэсгийн бүрэлдэхүүн тодорхой болоогүй байгаа тул хэлэлцэх асуудлыг хойшлуулах горимын саналаар санал хураалт явуулах юм байна.

Эхлээд хэлэлцэх 4 хэлэлцэх асуудалтай холбоотой саналтай гишүүн

байвал саналаа өгнө үү. Энэ тийм хэлэлцэх 4 асуудал байгаа юм. Энэтэй холбоотой юм байна уу гэж асууж байгаа юм.

Адьяаа гишүүн саналаа хэлье. Хэлэлцэх асуудалтай холбогдуулан Адьяаа гишүүн саналаа хэлье. Адьяаа гишүүний микрофоныг өгье.

Ш.Адьяаа: Түрүүн Шүүхийн тухай хуулийн тэр 7.3 байх. Би зарчмын зөрүүтэй санал гаргаад Хууль зүйн байнгын хороо дэмжээгүй. Тэгээд нэгдсэн чуулган дээр дэмжигдсэн байгаа байхгүй юу. Тэгээд Их Хурлын даргаас чиглэл өгөөд Дээд шүүх тэр сургалтын асуудлыг зөвхөн шүүгч нартай Шүүхийн ерөнхий зөвлөл бусад боловсон хүчний асуудлыг хариуцна гэсэн ийм томъёоллоор энийг оруулъя гэж ярьсан гэсэн ийм мэдээллийг Их Хурлын дарга надад өгсөн. Энэний тухай мэдээлэл ирсэн юм уу Цогтбаатар даргад?

Б.Энх-Амгалан: Шүүхийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуультай холбогдуулаад ажлын хэсэг дээр өнөөдөр Сандаг-Очир гишүүн, бас миний бие, дээр нь Оюунчимэг гишүүн бид 3 хуралдаж тэгээд яг энэ шүүхийн тухай, энэ сургалттай холбоотой асуудлаар санал солилцоод шүүхийнхэн өөрсдөө хоорондоо бүх асуудлаа тохироод, нэг мөр ойлголтод хүрээд зарчмын зөрүүтэй саналгүйгээр ингэж хураалгая гэж орж ирээд эхний санал нь хураагдчихсан. Одоо хэлэлцэх асуудал дээр энэ орж ирнэ.

Ш.Адьяаа: Тэгэхлээр ойлголцож. Шүүхийн ерөнхий зөвлөл, Дээд шүүх хоёр ойлголцчихсон юм байна шүү дээ?

Б.Энх-Амгалан: Бүгд ойлголцчихсон гэсэн үг.

Ш.Адьяаа: Тэгэхлээр нэг ойлголтын талаар. За за, би тэрийг л асууя.

Б.Энх-Амгалан: Шүүхийн сургалтын академи хүртэл ойлголцчихсон байна лээ. Тийм.

Ш.Адьяаа: Яагаад гэхээр дэмжигдсэн учраас энэний Дээд шүүх, Шүүхийн ерөнхий зөвлөл хоёр энэ Сургалт, судалгааны төвийн талаар бас их зөрүү ойлголттой бас.

Б.Энх-Амгалан: Тийм, эхлээд бол зөрүү ойлголт байсан. Одоо зөрүү байхгүй болчихсон.

Ш.Адьяаа: Энийг надаа зарчмын зөрүүтэй санал гаргасан гишүүний хувьд бас энэ Байнгын хороон дээр өөрийн байр суурь илэрхийлж энийг яриарай гэсэн учраас би ярьж байгаа юм шүү. Баярлалаа.

Б.Энх-Амгалан: Асуудал хэлэлцэх үед та бас саналаа протоколд үлдээгээрэй.

Ингээд хэлэлцэх 4-н асуудалтай холбогдуулаад гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа. Одоо хэлэлцэх асуудлаар өөр саналтай гишүүн байхгүй байгаа учраас хэлэлцэх асуудалдаа оръё.

Нэг горимын санал гарсан. Тэр горимын саналаар санал хураалт явуулъя.

Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн ажлын хэсгийн бүрэлдэхүүн тодорхой болоогүй байгаа тул хэлэлцэх асуудлын дарааллаас хойшлуулах горимын санал гаргаж байна. Энэ удаагийн дарааллаас энэ асуудлыг хойшлуулъя гэж 5 дахь асуудал байсан. Санал хураалт гишүүд ээ энэ асуудлыг хойшлуулъя гэсэн томъёоллоор. Ажлын хэсгийн бүрэлдэхүүн тодорхой болоогүй байгаа гэнэ. Тийм тул энэ тийм, энэ удаа ингээд хэлэлцэх асуудлаа хойшлуулъя гэж байгаа юм байна.

Санал хураалтад 10 гишүүн оролцож, 8 гишүүн дэмжиж, 80 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

Энэ асуудал энэ удаагийн хэлэлцэх асуудлаас хасагдлаа. Хэлэлцэх асуудалд оръё.

Улсын Их Хурлын гишүүн Г.Занданишатар, Д.Тогтохсүрэн, Н.Учрал, Д.Цогтбаатар нарын гишүүд 2024 оны 5 сарын 14-ний өдөр өргөн мэдүүлсэн Монгол Улсын шүүхийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг эцсийн хэлэлцүүлгийг хийе.

Хуулийн төслүүдийг Байнгын хорооны болон чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх санал, дүгнэлтийн төсөл боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийн танилцуулгыг ажлын хэсгийн ахлагч, Улсын Их Хурлын гишүүн Цэндийн Сандаг-Очир танилцуулна. Сандаг-Очир гишүүний микрофоныг өгье. Ажлын хэсгийг оруулаарай.

Ц.Сандаг-Очир: Байнгын хорооны эрхэм гишүүд ээ,

Улсын Их Хурлын гишүүн Д.Цогтбаатар, Г.Занданишатар, Н.Учрал, Д.Тогтохсүрэн нарын гишүүдээс 2024 оны 5 дугаар сарын 17-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Монгол Улсын шүүхийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг 2024 оны 5 дугаар сарын 30-ны өдрийн чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцэж, эцсийн хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Хууль зүйн байнгын хороонд шилжүүлсэн.

Төслийг хэлэлцүүлэгт бэлтгэх үүрэг бүхий ажлын хэсэг 2024 оны 6 дугаар сарын 3, 4-ний өдөр хуралдаж Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 42.2.3-д заасныг баримтлан хуулийн төслийн

зарим заалтаар дахин 2 санал хураалгах шаардлагатай гэж үзсэн болно.

Нэгдсэн хуралдааны анхны хэлэлцүүлгээр олонхын дэмжлэг авсан саналуудыг төсөлд нэмж тусган төслийн агуулга, бодлого, зарчмыг алдагдуулахгүйгээр үг хэллэг, дэс дараалал, бүтцийн шинжтэй засварыг хийж, эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн төсөл болон эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн тухай танилцуулга, зарчмын зөрүүтэй саналын томъёоллыг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг хүсье.

Б.Энх-Амгалан: Сандаг-Очир гишүүнд баярлалаа. Хэлэлцэж байгаа асуудалтай холбогдуулан хуралдаанд оролцож байгаа албан тушаалтнуудыг танилцуулъя.

Улсын Дээд шүүхийн Захиргааны хэргийн танхимын тэргүүн Д.Мөнхтуяа, Улсын дээд шүүхийн Эрүүгийн хэргийн танхимын шүүгч Б.Батцэрэн, Улсын дээд шүүхийн Иргэний хэргийн танхимын шүүгч Н.Баярмаа, Шүүхийн ерөнхий зөвлөлийн дарга Л.Энхбилиг, Шүүхийн сахилгын хорооны дарга Ц.Давхарбаяр, Шүүхийн ерөнхий зөвлөлийн гишүүн Н.Баасанжав, Шүүхийн ерөнхий зөвлөлийн гишүүн Мөнгөнцэцэг, Шүүхийн сахилгын хорооны гишүүн Д.Ариунтуяа, Улсын дээд шүүхийн Тамгын газрын дарга С.Заяадэлгэр, Улсын ерөнхий прокурорын туслах прокурор, Зөрчлийн хэрэг бүртгэх ажиллагаанд хяналт тавих хэлтсийн дарга Ц.Батболд, Шүүхийн ерөнхий зөвлөлийн Хуулийн хэлтсийн дарга Б.Оюунгэрэл, Хууль зүй, дотоод хэргийн яамны ахлах шинжээч Ш.Цолмон, Улсын ерөнхий прокурорын газрын Хэрэг бүртгэх, мөрдөн байцаах ажиллагаанд хяналт тавих хэлтсийн дарга Д.Баянжаргал, Цагдаагийн ерөнхий газрын Хуулийн хэлтсийн дарга Б.Батзориг, Улсын дээд шүүхийн Шүүхийн сургалт, судалгаа, мэдээллийн хүрээлэнгийн захирал Д.Эрдэнэчимэг гэсэн ийм бүрэлдэхүүнтэй ажлын хэсэг оролцож байна.

Ажлын хэсгийнхэн багтаад урагшаагаа суучаарай. Хариулт өгөх шаардлагатай болж магадгүй. Ажлын хэсгийг танилцуулж дууслаа.

Танилцуулгатай холбогдуулан асуух асуулттай гишүүд байвал нэрсээ өгнө үү.

Алга байна.

Гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа.

Танилцуулгатай холбогдуулан энэ чинь эцсийн хэлэлцүүлэг учраас үг хэлдэггүй тээ горим нь? Тэгвэл Сэргэлэн гишүүн асуулт асууя. Сэргэлэн гишүүний микрофоныг өгье.

Ц.Сэргэлэн: Баярлалаа. Асуулт ч гэхэд бас арай ч асуулт биш юм. Би ер нь тэгэхдээ энэ микрофон авсных энэ протоколд тэмдэглүүлэхээр үг хэлье гэж бодсон юм.

Хуулийн төслийн 5.71 дүгээр зүйл буюу 71.1.28-71.1.31 дэх заалтуудтай холбогдуулан би хэдэн үг хэлж протоколд тэмдэглүүлье гэж бодсон юм. Энэ яг ямар асуудлыг хэлээд байна вэ гэвэл энэ хууль дээр тусаж орж ирж байгаа цахимжуулалтын асуудал. Тэгэхлээр цахимын асуудал гэдэг бол хэн болгон мэдэж л байгаа л даа. Энэ бол ерөөсөө техник хангамж, программ хангамж хоёрыг л хэлдэг.

Энэ цахимжуулах асуудал бол ойлгомжтой. Хөрөнгө мөнгө нь шийдэгдчих юм бол асуудалгүй шийдэгдээд хийгдээд л явна. Хийхээс ч өөр аргагүй л ийм асуудал. Энэ хийгдэнэ. Гэтэл энэний нөгөө талд нь нэг асуудал байдаг. Энэ бол кибер аюулгүй байдлын асуудал.

Ялангуяа шүүхийн мэдээллийн систем гэдэг өөрөө онц чухал, маш нууцаас эхлээд хувь хүний мэдээлэл гэх мэтчилэн олон онц ноцтой мэдээллүүд, дээр нь гэмт хэргийн мэдээллүүд, нотлох

баримтын тухай мэдээллүүд гэх мэтчилэн яриад байвал их олон чухал чухал ач холбогдол бүхий мэдээллүүдийг багтаасан ийм мэдээллийн систем болох нь дамжиггүй.

Гэтэл энэний кибер аюулгүй байдлыг онцгойлон анхаарч хамгаалалтыг дээд зэргээр хийхгүй бол юун цахимжуулсан эргээд шүүх маань өөрөө хэн нэгний хараат байдалд орох ийм эрсдэл бий шүү. Үүнийг онцгой анхаараарай.

Яагаад би энэийг хэлээд байгаа юм гэхлээр энэ хамгаалалт гэдэг ухагдахуун чинь өөрөө шинжлэх ухааны ойлголт. Хамгаалалт гэдэг ухагдахуун өөртөө заавал аюул, занал, заналхийлэл гэсэн 3 ухагдахууныг агуулж явдаг ийм асуудал. Тэгэхлээр манай шүүхийнхэн энэ цахимжуулалтын асуудлыг хийгээд заавал энэ миний саяын хэлсэн энэ аюул байна уу, занал байна уу, заналхийлэл байна уу гэдэг асуудал дээр эрсдэлийн үнэлгээгээ нэгдүгээрт маш сайн хийлгэж байх хэрэгтэй. Энэ нь тэгээд бодитой байна уу, эсвэл болзошгүй байна уу гэдгийг анхаарна биз. Ер нь амьдрал дээр хараад байхад манай төрийн байгууллагуудын систем рүү маш олон кибер халдлага үйлдэгдэж байгаа. Бүүр тоог нь хэлэх юм бол тоймгүй олон тоо байдаг юм байна лээ.

Шүүх бол өөрөө хүний эрхийг хамгаалах, хангах, хүний эрхийг хөндсөн ийм олон мэдээллийг хадгалж байдаг учир энэ рүү халдах халдлага бол дээд зэргийн юм байна гэдгийг би хэлэх гээд байгаа юм. Ялангуяа сүүлийн үед яригдаад байгаа энэ олны анхаарлыг татсан гэмт хэргүүд дээр энэ мөнгөтэй, авлига албан тушаалын гэмт хэргүүдэд бол асар их мөнгө хэрэглэж байдаг. Наадуул чинь ямар ч чадалтай энэ цахимаар мэргэшсэн хүнийг хөлслөөд кибер халдлага хийлгэж чадна. Ямар ч мундаг хакерыг хөлсөлж чадна.

Тийм учраас энэ кибер аюулгүй байдлын хамгаалалт гэдэг асуудлыг

онцгой анхаарна биз дээ. Хамгаалалт гэхлээр нэгдүгээрт техникийн асуудал байдаг.

Хоёрдугаарт хүний нөөцийн асуудал байгаа юм.

Гуравдугаарт нэг зүйлийг онцгой анхаарахгүй бол болохгүй. Тэр юу вэ гэхлээр энэ программ хангамжийг хувийн аж ахуйн нэгжүүдээр хийлгэж байгаа одоо. Өөр ямар ч арга байхгүй. Гэрээ байгуулаад. Хувийн аж ахуйн нэгжээр хийлгэсэн программ хангамжтай шүүх байх юм тэгээд бол 100 хувь тэр программ хангамж хийсэн аж ахуйн нэгжийн хараат болно л гэсэн үг. Үүнийгээ тэгээд ямар гаргалгаа.../минут дуусав./

Д.Цогтбаатар: Сэргэлэн гишүүний микрофоныг өгье. 1 минут.

Ц.Сэргэлэн: Тэгэхлээр программ хангамжийг болж өгвөл шүүх өөрөө өөрсдөө хийх тийм ямар боломж байдаг юм тэрийг эрэлхийлэх нь зүйтэй байх гэдэг би саналыг хэлж байгаа юм шүү. Хэрвээ тэр гаднын аж ахуйн нэгжүүдээр гэрээний үндсэн дээр хийгдвэл тэгээд л хараат болно. Мөнхийн мөнгө урсана гэсэн үг. Наад программ хангамжийг чинь ингэдэг юм. Ерөөсөө хийлээ, жоохон хугацаа өнгөрлөө, хөгжүүлэлт хийх хэрэгтэй болно. Хөгжүүлэлт хийнэ, нөгөө программ хийсэн нөхдүүд чинь мөнгө нэхээд хэвтчихнэ. Мөнгө өгөхгүй бол хийхгүй ээ. Зайлишгүй мөнгө төлнө. Ахиад ингэнэ. Тэгээд л ингэсээр яваад ердөө хэдэн жил энэ программ хангамжийн чинь анх хийсэн хөлсийг чинь хэд нугалаад л авчихна.

Дээрээс нь энэ программ хангамжид хадгалагдаж байгаа программд, системд хадгалагдаж байгаа ямар ч мэдээлэл рүү халдах эрх нь тэд нарт байж байгаа. Яах вэ хуулиар зохицуулсан юм бий. Гэхдээ тэрүүгээр явна гэж амьдрал дээр бол байхгүй. Тийм учраас би энэ шүүхийн мэдээллийн.../минут дуусав./

Д.Цогтбаатар: Адъяаа гишүүний микрофоныг өгье.

Ш.Адъяаа: Шүүхийн тухай хууль өнөөдөр ингэж батлагдаж байна. Монгол Улсын Үндсэн хуулийн өөрчлөлтийн дагуу Монгол Улсын шүүхийн тухай хуулийг бид баталсан байгаа. Тэгэхдээ энд Монгол Улсын Үндсэн хуулийн бүтцийн байгууллага болох Шүүхийн сахилгын хороо, Шүүхийн ерөнхий зөвлөл гэдэг энэ хоёр байгууллагын эрх, үүргийн асуудал бол энэ Шүүхийн тухай хуулиар бас нэлээн бүрхэг байсан. Түүний дотор өнөөдөр шүүх эрх мэдлийг гагцхүү шүүх хэрэгжүүлнэ гэдэг энэ Үндсэн хуулийн зарчмын тухайд миний бие бас Дээд шүүхийн харьяанд Шүүхийн сургалт, судалгааны төв байх нь өнөөдөр бас энэ Үндсэн хуулийн үзэл баримтлалтай зөрчилдөж байна гэсэн бодлын үүднээс Шүүхийн ерөнхий зөвлөлийн харьяанд өнөөдөр шүүхийн сургалт, судалгаа, боловсон хүчний бүх асуудал байх ёстой гэдэг ийм зарчмын үндсэн дээр зарчмын зөрүүтэй санал гаргаж Улсын Их Хурлын нэгдсэн чуулган дээр дэмжлэг авсан.

Тэгэхдээ энд Монгол Улсын дээд шүүх, Шүүхийн ерөнхий зөвлөл харилцан Улсын Их Хурлын даргын хэмжээнд ярилцаж зөвхөн шүүгчтэй холбоотой асуудлыг Дээд шүүх хариуцаж сургалтын асуудлыг шийдье, бусад боловсон хүчний асуудлыг Шүүхийн ерөнхий зөвлөл шийдье гэсэн ийм ойлголтыг Улсын Их Хурлын даргаас өгсөн чиглэлийн дагуу ажлын хэсэг дээр бас шийдлийг олсон байна. Энийг би дэмжиж байгаа. Нэгэнт шүүх эрх мэдлийн хоёр том байгууллага энэ шилжилтийн үеийн энэ цаг үед бас ингэж харилцан ойлголцох нь шүүхийн цаашидын бие даасан байх, хараат бус байх шүүхийн боловсон хүчний тухайд бид бас ийм байдлаар цаашид явж байж энэ шийдэлд хүрэх ёстой гэсэн учраас энэ ажлын хэсгийн саналыг бид дэмжиж байгаа юм.

Ер нь бол Монгол Улсын Үндсэн хуульд заасан шүүх бие даасан байх, шүүх хараат бус байх энэ зарчим бол шүүх эрх мэдэл бол зөвхөн шүүн таслах ажиллагаагаа л хариуцаж явах ёстой. Энэ асуудал бол цаашидаа засаж залруулагдах ёстой гэсэн ийм зарчмын байр суурьтай байгаа. Шүүхийн ерөнхий зөвлөл, Шүүхийн сахилгын хороо гэдэг энэ Үндсэн хуулийн бүтцийн байгууллага бол шүүхийн боловсон хүчин, хөрөнгө санхүүгийн асуудал, түүнчлэн сахилга хариуцлага алдсан шүүгчдийн асуудлыг өнөөдөр Монгол Улсын Үндсэн хуулийн бүтцийн байгууллагын хувьд зайлшгүй хуулиар энэ асуудлыг бие дааж явуулах нь өнөөдөр Үндсэн хуулийн чинь үзэл баримтлалын асуудал шүү гэдгийг би энд хэлье. Энийг би зориуд протоколд тэмдэглэж үлдээж байгаа юм.

Тэгэхлээр өнөөдөр бид шүүх бие даасан, шүүх хараат бус байх энэ зарчим өнөөдөр хууль, эрх зүйн хүрээнд, бодлогын хүрээнд, Үндсэн хуулийнхаа үзэл баримтлалын хүрээнд л явах ёстой гэсэн энэ зарчмыг дараа дараагийн парламент, дараа дараагийн Хууль зүйн байнгын хороо энэ бодлогын хэмжээнд авч явж байж цаашид шүүхийн нэр хүнд, шүүхийн боловсон хүчин, шүүх бие даасан байх, шүүх хараат бус байх энэ Үндсэн хуулийн зарчим чинь энэ ардчилсан төрийн үед баталгаажих ёстой гэдэг ийм байр суурьтай байгаагаа илэрхийлье.

Анхаарал тавьсанд баярлалаа.

Д.Цогтбаатар: Баярлалаа. Ингээд гишүүд танилцуулгатай холбогдуулан асуулт асууж дууслаа.

Эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн төслийг гишүүдэд тараасан байгаа.

Хуулийн төсөлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд нэрсээ өгнө үү.

Асуулт, хариулт сая яваад дуусчихсан байна. Тэгвэл хуулийн

төсөлтэй холбогдуулан гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа.

Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 42.2.3 дахь заалтын дагуу хуралдаанд оролцсон гишүүдийн гуравны хоёроор ишидэх 2 санал байгаа. Эдгээр 2 санал дэгийн хуулийн 42.2.3-д заасны дагуу дахин санал хураалт явуулахыг дэмжье гэсэн саналаар санал хураалт явуулмаар байна.

Би тэгээд энийг юу уншаад танилцуулчихъя. Тэгэхлээр саяын юу гуравны хоёроор асуудлыг дэмжиж ишидвэрлэе гэсэн саналаар санал хураалт явуулъя. Дэмжье гэсэн томъёоллоор. Ингээд гуравны хоёроор санал хураахаар бид нар ишидвэрлэлээ. Ингээд санал хураалгах саналаа танилцуулъя. Саналын томъёоллыг.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.2.3-д заасны дагуу хураалгах санал.

1.Төсөлд доор дурдсан агуулгатай 5 дугаар зүйл нэмэх:

“5 дугаар зүйл. Монгол Улсын шүүхийн тухай хуулийн 72 дугаар зүйлийн 72.1.6 дахь заалтын “шүүгч болон” гэснийг хассугай.”. Санал хураалт. Манайхан дэмжинэ шүү энэ дээр. Ямар ч гэсэн гэхдээ гуравны хоёр боллоо. Гэхдээ би саналаа дэмжиж өгсөн. Ажлын манай албаныхан энэ дээр намайг протоколд санал дэмжиж өгсөн гэж тэмдэглээрэй. Дараагийн саналдаа оръё.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.2.3-д заасны дагуу хураалгах санал.

1.Төслийн 3 дугаар зүйлийн 9 дүгээр зүйлийн 9.2.2 дахь заалтын “үндсэн эрхэд” гэснийг “амь нас, эрүүл мэндэд” гэж өөрчлөх. Санал хураалт.

Энийг бас манайхан дэмжинэ шүү. Энэ дээр би, миний санал дэмжсэн боловч, би өөрөө горимын санал гаргаж байна. Энэ саяын санал хураалтад би санал дэмжиж өгсөн. Машин хоёр дахиа ч ажилласангүй. Тийм учир тэгэхээр бас саяын санал хураалтыг хүчингүй болгоё гэсэн томъёоллоор санал хураалт.

Энэ санал дэмжигдлээ. Гэхдээ би машинаа ахиж янзалж байж яахгүй бол энэ эсрэг гараад болохгүй байна. Санал хураалт түрүүний санал хүчингүй болоод дэмжигдлээ.

Түрүүн уншиж танилцуулсан томъёоллоор дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя.

83.3 хувиар санал дэмжигдлээ. Сая одоо орж байна. Тийм, ингээд санал дэмжигдлээ.

Одоо зарчмын зөрүүтэй саналаар санал хураалт явуулж эхэлье. 2 саналтай байгаа. Сая хураачихсан 2 санал.

Монгол Улсын шүүхийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн эцсийн хэлэлцүүлгийг явуулж дууслаа.

Хуулийн төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх Байнгын хорооны танилцуулгыг чуулганы нэгдсэн хуралдаанд Улсын Их Хурлын гишүүн Раднаасэд танилцуулчих уу? Раднаасэд гишүүн танилцуулна. Хоёрдугаар асуудал руугаа оръё.

15.39 цаг

Монгол Улсын шүүхийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдтэй холбогдуулан боловсруулсан Монгол Улсын шүүхийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг хийе.

Хуулийн төслийн талаарх танилцуулгыг Улсын Их Хурлын гишүүн Цэндийн Сандаг-Очир танилцуулна. Сандаг-Очир гишүүний микрофоныг өгье.

Ц.Сандаг-Очир: Байнгын хорооны эрхэм гишүүд ээ,

Нээлттэй шүүх хуралдааны бичлэгийг шүүхийн цахим хуудаст, эс үгүй бол шүүхийн нээлттэй бусад цахим платформд байршуулах, үүнийг хэрэгжүүлэх хүрээнд цаасан баримтыг цахим баримтаар хөрвүүлэх, улмаар хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг цахимжуулахтай холбоотой бүх шатын шүүхэд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг цахимаар хэрэгжүүлэхэд шаардлагатай программ хангамж, техник, технологийн асуудлыг шийдвэрлэсний дараа дагаж мөрдөх хугацааг тогтоох шаардлагатай байна.

Түүнчлэн шүүгч зэрэг дэвтэй байх бөгөөд шүүгчид зэрэг дэв олгох журмыг Улсын Их Хурал батална гэж Монгол Улсын шүүхийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд тусгасан. Шүүгчид олгох зэрэг дэвийг тогтоох Улсын Их Хурлын тогтоолын төслийг боловсруулж өргөн мэдүүлэх, санхүү төсвийн асуудлыг шийдвэрлэх хугацаа шаардлагатай байгаа тул холбогдох хэсэг, заалтыг 2025 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөхөөр тусгалаа.

Иймд ажлын хэсэг дээрх асуудалтай холбогдуулан Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 44 дүгээр зүйлийн 44.5-д заасны дагуу Монгол Улсын шүүхийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн төслийг боловсрууллаа.

Байнгын хорооны эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын шүүхийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай

хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн төслийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг хүсье.

Д.Цогтбаатар: Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39.10-д Байнгын хороо хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэнэ гэж заасны дагуу хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцье.

Монгол Улсын шүүхийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн төслийн I дүгээр зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд нэрсээ өгнө үү.

Ганбат гишүүнээр тасаллаа. Сүхбаатар гишүүний микрофоныг өгье.

Ж.Сүхбаатар: Би асуулт гэхээсээ гадна Шүүхийн ерөнхий зөвлөлийнхөн маань байгаа учраас зүгээр нэг юмыг хэлье. Би чинь Шүүхийн хуулийн ажлын хэсгийн гишүүн байсан. Одоо өөрөө шүүгдэгч болчихоод явж байгаа. Яах вэ амьдрал дээр бас танилцаад л явж байна л даа бас. Энэ чинь өөрөө бас танилцах ёстой юм байна. Миний бодож байснаас олон юм өөр байдаг юм байна.

Тэгэхээр би зүгээр юу хэлэх гэж байна вэ гэхээр жишээлбэл их деталь байгаад байгаа юм. Траст дэ процесс гэж энэ нөгөө яг процесст итгэх ёстой. Тэгэхээр нээлттэй хуралдаанд л аягуй гоё ингээд бичлэг явуулъя, цахимаар явуулъя л гэж яриад байгаа юм. Тэгэхээр тэр дотор моментуудаа анхаармаар юм байна лээ шүү дээ. Тэр журмаа хийхдээ хүртэл.

Жишээлбэл, нээлттэй хуралдаан бичлэг хийж эхэллээ гэдгээ мэдэгдэх ёстой юм уу, яах ёстой юм? Одоо түрүүн би хуралдаанд ингээд ороод сууж байхад эхлээгүй байхад нь л тэр хэсгийг нь ингээд л гаргаад байж байна. Би мэдэхгүй байгаа байхгүй юу. Тэгээд л хаана ч суух нь ч ойлгомжгүй. Шүүгдэгч гээд нэг юм тавьчихсан юман дээр сууж

байсан чинь өө та энд суухад нөгөө хүнтэйгээ ойрхон байна, хойшоо суу гээд тавьчихсан юмнаас өөр. Тэгээд л тэр хооронд ингээж байгаа хооронд л нөгөө бичлэг нь яваад байгаа юм. Хүн харахад бол тэр чинь хуралдаан болоод байгаа юм уу, энэ тэр хуралдаан эхэлсэн ч юм уу тэгээд харахад их нээлттэй яваад байх шиг байгаа юм.

Тэгэхээр зүгээр би юу хэлэх гээд ийм деталиудаа их бодохгүй бол л нээлттэй цахимаар эхэлж байгаа бол энэ чинь бүх юм протокол, цаана нь ингээд харагдаж байгаа шүү дээ сэтгүүлч улсуудад. Тэгэхээр энэ чинь яг эхэлж байгаа бол тэр эхэлж байгаа гэдгээ тэр хуралдаан эхэлж байгаа тэр цахим бичлэг явж байгааг нь өмгөөлөгчид нь байдаг юм уу, тухайн хүмүүст нь сануулах ёстой байдаг юм уу, яах ёстой байдаг юм энэ чинь? Хамраа ухаад сууж байвал яах вэ энэ чинь? Ингээд л жишээлбэл би амьдрал юм л даа энэ чинь. Тэгээд л нөгөө хүн нь харж байхад юу гэж бодох юм? Тийм зарим хүнийг чинь ингээд явж байвал өө хэнэг ч үгүй царайлаад сууж байна гэх юм уу, яах юм? Зарим хүн чинь масктай сууж байвал яах юм? Эрүүл мэндийн тодорхойлолттой хүн заавал масктай суух ч гэдэг юм уу. Би зүгээр яах вэ төрсөн бодол.

Тэгэхээр энэ нээлттэй нэвтрүүлж байгаа нөхцөлд тэр процессынхоо юман дээр тэр анхаараарай. Жишээлбэл, Америк эд нарт чинь нөгөө шүүгчийн зургийг чинь нөгөө юугаар л зурдаг шүү дээ. Зурган хэлбэрээр харуулдаг барьдаг. Тэгэхэд манайд чинь тэр нээлттэй л нэвтрүүлнэ гэхээр яг энэ Их Хурлын танхим шиг л ингээд л нүүр амыг нь харуулаад л, татаад л. Нөгөө хүн ямар хувцас өмсчихсөн байна, яаж хөдөлж байна, нүд ам нь яаж байна гээд.

Тэгэхээр энэ асуудлууд дээрээ тэр шүүхийн яригдаж байгаа зүйлүүдийг яах ёстой болохоос тэр хүний нүд, царай, нүүр царайг харуулах гээд байгаа юм байхгүй шүү дээ тэр чинь. Гол юм нь тэр. Агуулга дээр тэр хүн мэтгэлцээд юу

яриад байгаа юм, ямар аргументаа дэвшүүлээд байгаа юм. Тэгэхээр аль хэсэг нь ингэж ингэж детальчилж харуулах юм, аль хэсгийг нь татаж болох юм. Оператор дураараа тэгээд л нэг хэсгийг нэг нөхөр, залуу тэнд сууж байснаа л юмаа ингээд л татаад л, тэр хүнийг нь татаж аваад л тэгээд л нэвтрүүлээд байх юм уу, яах юм? Энэ асуудлууд дээр их тийм их ерөнхий юман дунд, далбаан дор их зүгээр юм явчхаад байгаа шүү. Тэгэхээр зэрэг энийгээ бодоорой. Хүнийг яаж харуулах вэ гэдэг чинь ч гэсэн. Одоо бол бид нар хаалттай аль болохоор бага явуулаад, маш нууц юм уу, хүүхдийн эрх юм уу, тодорхой хохирогчийн эрхтэй холбоотой асуудал дээрээ хүсэлт дээр нь хаалттай явуулъя. Бусад тохиолдолд нээлттэй явуулъя.

Тэр нээлттэй явуулж байх үеийнхээ юмыг сайн анхаараарай. Тэгээд дээр нь тэр шүүхийн гадаа хүмүүс янз бүрийн сэтгэгдлээ илэрхийлдэг. Трамп бол сая хэд хэдэн удаа шүүхийн талаарх санал шүүмжлэлээ хэлээд л гаг ордер /gag order/ гээд нөгөө шүүгчийн хориглосон үгийг хэрэглэсэн учраас 1000 долларын торгууль 3 удаа бараг төллөө шүү дээ.

Яагаад гэвэл шүүх хуралдааны гадаа, танхимын гадаа шүүхийн явж байгаа процессын талаар ингээд юм яриад байсан учраас гээд ингэчихсэн гэдэг ч юм уу. Ингээд цаашидаа ингээд энэ стандартуудаа их нарийсгаж яахгүй бол одоо энэ Их Хурал дээр ч гэсэн хуучин ингээд нэгдсэн ийм камер ажиллахгүй байх үед дуртай операторууд нь ингэж татаж гаргаж ирж ярьдаг, ингээд цацдаг байсан байхгүй юу. Тэр нь аягүй сөрөг нөлөөлдөг байсан.

Барууны оронд бол тийм юм байхгүй шүү дээ. Яг ингээд л тодорхой хэсгийг нь харуулна гэдэг тэр дүрэм, журмууд нь байдаг. Тэгэхээр энэ дээр нөгөө бид хэд чинь нөгөө мэдлэг байхгүй, нөгөө камер юмаа операторын мэдэлд л өгчихдөг. За чи тэгээд сайхан нээлттэй нэвтрүүлээрэй гээд хаячихдаг. Нөгөөдөх

нь байж байгаа юмаараа л дуртай өнцгөөрөө харуулаад байдаг. Тэр нь эерэг, сөрөг нөлөөлөх байхгүй юу хүнд. Өө ингээд муухай хараад суугаад байна, эсвэл инээгээд байна, эсвэл бохь зажлаад байна ч гэдэг юм уу ингээд л явна шүү дээ гэх мэтээр. Энийг нь эхлээд сануулдаг юм уу, яадаг юм? Энэ мэтийн юмыг зүгээр санаа энэ журам.../минут дуусав./

Д.Цогтбаатар: Минутаа нэмж авах уу яах вэ, тодруулах уу? Сүхбаатар гишүүний микрофоныг өгчихье.

Ж.Сүхбаатар: Тэгэхээр энэ ингээд хуульчийн нүдээр, эрх зүйчийн нүдээр ингээд харахаар зэрэг бид нарын юм бол ерөөсөө яагаа ч үгүй байна лээ шүү. Тэгээд тэр хуралдаанаа тэр эхэлж байхад. Тэгэхээр энэ нээлттэй хуралдаан хийж байхад энэ бол тайз биш, улс төрийн шоу хийдэг тайз биш. Нээлттэй хуралдаан дээр мэдээллийг дураараа үзэл бодлоо илэрхийлэх иргэн хүн эрхтэй гэж байгаа боловч шүүгчийн тэр явж байгаа процессын талаар оролцогч талуудын тэр хэмжээний нээлттэй байдал тодорхой хуудас, хязгаарт яваад дуусах ёстой. Би бол нээлттэй хуралдааны талд анх Шүүхийн хуулийг хийхэд чинь Энхбаяр бид нар чинь тэр нээлттэй талаас нь энэ цахим юмыг чинь нэлээн нээлттэй болгож өгсөн шүү дээ. Одоо дараачийн тийм түвшин рүү орж ирэх. Тэгэхгүй бол хаалттай хуралдаанаар алх тогшоод хүний эрхийг зөрччихдөг явдал байгаа. Би бол тэрийг бол энэ хуулийн хэрэгжилтийн энэ явцад их сайн хангах ёстой. Тэгэхээр ийм деталь дээр манай Шүүхийн ерөнхий зөвлөлийнхөн байгаа учраас журам эд нар дээр анхаарахад энэ бас нарийн сургалт байх юм байна лээ шүү. Тэгээд энийг нэвтрүүлдэг хүмүүсийг хүртэл сургалтад хамруулах ёстой юм билээ.

Д.Цогтбаатар: Асуултад хариулах уу? Яагаад гэвэл энд зүгээр бас уг байсангүй. Тийм, хэн хариулах вэ ажлын хэсгээс? 4 дүгээр микрофон.

Л.Энхбилэг: Гишүүддээ өдрийн мэнд хүргэе. Цахимжилттай холбоотой Шүүхийн ерөнхий зөвлөл журам батална. Одоо энэ нээлттэй, ил тод байдалтай холбогдуулж цахимаар хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа явагдах тэр үйл ажиллагааг нь журмаараа зохицуулна. Энийг Ерөнхий зөвлөл журмаар батлах ийм чиг үүргийг хуулиар олгож байгаа. Үүнтэй холбогдуулж Сүхбаатар гишүүний яг саяын ярьсныг бид анхаарч бас журмын төсөлдөө анхаарч явж байгаа. Баярлалаа.

Д.Цогтбаатар: Ганбат гишүүн.

Д.Ганбат: Ингээд шүүхийн ээлжит хууль орж ирээд гарч байна. Ямар ч байсан маргааш энэ чуулганы хамгийн сүүлийн чуулган болох байх. Ингээд батлагдах байх. Хэд хэдэн бид нар бас 2 туйл руу л яваад байх шиг харагдаад байгаа юм. Тэгээд олон нийтийн сэтгэл зүйд нийцүүлээд ингээд баахан хуулиуд гаргаад байдаг. Тэр нь яг амьдрал, ахуй дээр нөгөө шүүхийг яг хараат бус байлгах тэр Үндсэн хуулийн зарчим, шударга байх, шударга ёсыг тогтоох энэ чиглэл рүүгээ явж чадаж байна уу, үгүй юү? Сая миний өмнөх гишүүн бол ярилаа. Тэр яагаад яг шүүхийн танхим зургаар байдаг юм, яагаад фото зураг авдаггүй юм, яагаад хар зургаар явдаг юм тэр чинь бүгдээрээ л учиртай байхгүй юу даа. Энэ олон зуун жил энэ шүүх хараат бус шүүхийг бий болгох гэж ирсэн. Бий болж чадаж байгаа улс орнуудад тэгдэг байна. Тэгтэл манайд бол ерөөсөө тийм үзүүлэн маягтай, бараг л жүжиг тоглож харуулах гээд байдаг. Ийм байж болохгүй ээ.

Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлт хэд хэдэн сайн өөрчлөлтүүд орсон. Тэрний нэг нь бол Шүүхийн ерөнхий зөвлөл, Шүүхийн сахилгын хороо энэ тэр бол Үндсэн хуулийн байгууллага болсон л доо. Энэ бол шүүхийн хараат бус байх, энэ рүү явж байгаа алхмууд байхгүй юу. Тэгээд хэд хэдэн хууль батлахдаа бид нар тэр Улсын дээд шүүх рүү Шүүхийн

ерөнхий зөвлөлийн эрхийг аваад байдаг. Шүүх бол ерөөсөө л тэр хянан таслах үйл ажиллагаагаа л хариуцаж хийх ёстой. Тэрийг л хариуцах ёстой. Хараат бус болгохын тулд захиргаа, боловсон хүчин, мөнгө төгрөгтэй холбоотой, эдийн засагтай холбоотой энэ асуудлыг Шүүхийн ерөнхий зөвлөл нь л шийдээд л явах ёстой шүү дээ. Тэр 570 шүүгч байна уу? Нийтдээ 600 гаран шүүгч байх ёстой. Эд нар бүгдээрээ яг ав адилхан шүүгч нар.

Тэрнээс биш Улсын дээд шүүхийн Ерөнхий шүүгч юм уу, Дээд шүүхийн шүүгч нар нь яг нөгөө социализмын үеийн босоо тогтолцоо шиг манай Хууль зүйн сайдын хэлээд байгаачлан ийм хонгил хийх бололцоотой ийм нөхцөлийг бий болгож болохгүй байхгүй юу. Яг ажилд адил тэгш эрхтэй. Одоо энэ шүүх шийдэхдээ чанартай, чанаргүй шүүгч нараа аваад, чанартай чанаргүй шийдүүлсэн гэж явах юм уу? Шүүгч нар зэрэг, дэвтэй болох юм уу? Болоод тэгээд яах юм? Болчихсон л юм байна л даа энэ хуулиар. Болгож байгаа юм байна. Үүний ялгаа нь ямар байх юм? Ямар шүүгч нь ямар хэргийг шийдээд чанартай, чанаргүй. Иргэн бол бүх шударга шүүхээр л шийдүүлэх ёстой шүү дээ. Хуулийн дагуу хуулийг дээдэлдэг ийм шүүхээр шийдүүлж л гарах ёстой. Тэгээд энэ чинь бас нөгөө ямар шатлалын эмнэлэг байна тэрүүгээр орсон, гарсан ийм эмчлүүлсэн гээд ингэж явах юм уу, яах ёстой юм?

Нөгөө талаар энэ цалин пүнлүү бас их сонин болоод байна. ТҮК-ийн ажилчид маань энэ дараа сарын 1-нээс эхлээд цалин нь 3 сая 500 болж байгаа юм байна автобусны жолооч нар. Энэ бол маш сайн. Зөв зүйтэй байна. Нөгөө манай эмч нар, багш нар хэд болж байгаа билээ? Энэ ингээд бас шүүхийн цалин, шүүхийн захиргааны ажилтны цалин энэ тэрийг харахад эд нар чинь бас эмч нар бол насаараа суралцдаг, багш нар ч гэсэн. Шүүх бол маш нарийн үйл ажиллагаа л даа ийм тогтсон систем. Энэ хүмүүсийн авч байгаа цалин пүнлүү

хэд байна? Одоо энд чинь ажиллах хүмүүс олдох уу, үгүй юү? Багш нар 1 сая 500 байх шиг байна. Эмч нар бас тэр хавьцаа байна. Энэ шүүхийн захиргааны ажил.../минут дуусав./

Д.Цогтбаатар: Яах уу та гүйцээх үү? Би бас хариултыг нь эхлээд хууль санаачилж байгаа хүний хувьд эхлээд өгчихье. Тэгээд ажлын хэсгээс гүйцээгээд хариулаарай.

Шүүх бол угаасаа Ганбат гишүүнээ Шүүхийн хууль дээрээ Монгол Улсын шүүх нээлттэй байна гэдэг ерөнхий зарчимтай. Харин процессын хуулийнхаа дагуу аягүй олон хуулиудаар энэ дээр нь хаалт гаргахаас өөр гарцгүй ийм хуулиуд батлаад өгчхөөд байгаа байхгүй юу. Тэгээд энэ дээр нь юу гэдэг юм нэг байгууллагын залуухан дарга өшөө туршлагажаагүй нөхөр зүгээр юу хийж дараах үр дагавраа мэдэхгүйгээр нууц гээд л тавьчихсан бол тэр баримт нь нууцлагдахаас өөр үггүй болчихоод байгаа юм. Тэгээд шүүх дээр орж ирээд бүх шат руугаа орж ирээд энэ ийм юм болоод явж байна. Дараа нь нөгөө шүүхээ энэ хаалттай хийгээд байна гээд.

Өнөөдрийн жишээлбэл, Нууцын хууль үйлчилж байгаа нөхцөл байдал чинь ийм байгаад байгаа юм. Тийм учраас нээлттэй тэр хуульдаа анхнаасаа заасан үзэл санаандаа нийцүүлж үйл ажиллагааг нь засаж өгч байна гэсэн үг. Нэг.

Хоёрт, хэрэв гаднын практик яах юм бол ялангуяа хялбар ажиллагааны шүүх Америкийнх бол бүүр яг онлайн. Бүгдээрээ харж байдаг. Тэр хэд хэдэн бүүр од шүүгчид байгаа. Нөгөө шүүхийн тогтолцоондоо итгэл үнэмшил төрүүлэх үүднээс бүүр ийм од шүүгчид байгаа. Тэд нар нь оруулж ирээд шууд газар дээрээ шүүгээд, шүүгээд л, гаргаад явна. Тэр нь бүүр тэр чигээрээ онлайн нээлттэй. Бүүр тусгай суваг эд нар байж байгаа юм.

Тэгэхлээр энэ нээлттэй байх бол баруунд аль хэдийн бүүр гүн нэвтэрчихсэн зүгээр тогтолцоо биш энэ бүүр соёл болоод нэвтэрчихсэн байж байгаа юм. Тийм, яг үнэн. Сүхбаатар гишүүн тэн дээр жишээлбэл яг тодорхой хэд хэдэн юм улсын тийм. Айн? Үгүй ээ тэгэхдээ наадах чинь ёстой хамгийн их ил яригдаж байгаа шүү гишүүнээ. Тийм тийм. Тэгэхлээр би бол энэ дээр яг юу юу хаагдаж байгаа гэхлээр жишээлбэл, Үндэсний аюулгүй байдалтай, тагнуултай холбоотой асуудлууд бол уучлаарай. Энэ нээрээ энийг нээх боломжгүй. Эс үгүй бол мөрдөн байцаах үйл ажиллагаа эд нартай холбоотой энэ юмнууд л хаагдах ёстой юм л хаагдана. Өөр бусад бүх юм бол нээлттэй болж байгаа юм.

Би өөрөө ч гэсэн жишээлбэл Лондонд Монголын төрийн албан хаагчтай холбоотой кэйсийг өмгөөлөгчтэй нь хамтраад бүх мэдээ, баримтуудыг гаргаад Монголын өмгөөллийн стратегийг боловсруулаад л явж байсан. Тэгэхэд бүүр гайхалтай шүү. Тэднийх бол нэг шүүх дээрээ оччихсон асуудал бол ёстой манайд угаасаа хаалттай байх ёстой гэж бодож байгаа юмнууд чинь шүүх дээрээ очсон бол нээлттэй болчихдог юм байна лээ. Хаах ямар ч боломжгүй. Тэгж байж тэндээс жишээлбэл би яг дипломат үйл ажиллагааны практикт байсан хүн аягүй олон мэдээллүүд эд нар ингэж байсан байна гэдэг өөрөөр би олж авах боломжгүй мэдээллүүдийг олж авч байгаа байхгүй юу гэх мэт.

Тэгэхлээр тэрийг тэр үүднээс нь бид нар энийг нээж өгч байгаа юм. Өөр гүйцээгээд нэмээд ажлын хэсгээс хариулах уу? Хэн хариулах вэ?

Тэр зэрэг, дэв дээр гишүүнээ ийм юм байгаа шүү. Энэ чинь ямар нэгэн дарга, цэрэг ингээд үүсгэх гээд байгаа ёстой биш. Шүүгчийн эрх мэдэл хуульд заагдсанаараа тэр ямар зэрэг дэвтэй байхаас ялгараад, хамаараад шүүгчийн

эрх мэдэл юм ерөөсөө хөндөгдөнө гэж байхгүй.

Гэхдээ энэ чинь төрийн алба яах аргагүй олон жил ажиллачихсан хүмүүс тэрэнд, би ч гэсэн төрийн албанд тусгай албанд зөндөө ажиллаж байсан тэр зэрэг дэвийг санадаг ч хүн байхгүй энэ чинь харин дараа нь нөгөө ажил албан тушаал ахихад, эс үгүй бол цалин хөлс тооцоход энэ дээр л тооцогддог болохоос биш дарга, цэрэг болдог юм бо огтоос биш. Миний л лав ажиллаж байсан салбарт түшээ эд нар гэдэг чинь, харин тэр чинь дараа нь албан тушаал ахихад уу, цалин пүнлүү тооцоход уу тийм юмнууд л хэрэгтэй. Түүнээс тэр дээрээ үндэслээд дарга, цэрэг байгаад байдаг юм байхгүй.

Гэхдээ манайхан бас гүйцээгээд өөрсдөө хариулчих уу? Хэддүгээр микрофон? 2 дугаар микрофон.

С.Заяадэлгэр: Цогтбаатар даргын сая хэлсэн агуулга яг мөн. Улсын дээд шүүхээс энэ нээлттэй байдлын үндсэндээ шүүхийн ил тод, нээлттэй байдлыг хэрэгжүүлэх зарчмыг тодорхойлохдоо саяын тэр нээлттэй байя гэдэг зарчимдаа. Нууцын тухай хуулиар болон процессын холбогдох заалтаараа хэргийн оролцогчид хаалтаа хийе л гэхэд хаалттай болчихдог энэ процессыг өөрчилж байгаа. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх хуульдаа гэрч, хохирогчийг хамгаалах ч юм уу яг тухайлсан энэ заалтаараа хаагаад, Иргэний хуульдаа үндсэн эрх ноцтой зөрчил, Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх хуульд амь нас, эрүүл мэндэд ноцтой хохирол учруулахаас бусад бүх тохиолдолд шүүх хуралдааныг нээлттэй байя. Энэ нээлттэй байхаар шийдвэрлээд хийж байгаа хурлыг бас түрүүний хэлсэн хуульд заасан үндэслэлээр хаалттай болох оролцогчдын хүсэлтийг шүүх авч хэлэлцэнэ.

Шүүх хаалттай хийхээр шийдвэрлэсэн тохиолдолд бас үүнийг нь бас оролцогчид дээд шатад хянуулдаг

байя гэдэг ийм ойлгомжтой томъёоллуудыг энэ холбогдох хууль тогтоомжуудад хийж өгснөөр өмнө байсан энэ нууцалдаг, хаалттай байхаас өөр аргагүйд хүрдэг, эргээд шүүх хаалттай угаасаа байна гэдгээсээ болж үл итгэх байдалд хүрдэг. Энэ үйл ажиллагаанууд, байдлууд, нөхцөл байдлууд энэ хуулиар нэг мөсөн сайжирч засагдана гэсэн ийм хүлээлттэй байгаа.

Д.Цогтбаатар: 4 дүгээр микрофон хариулах уу? 4 дүгээр микрофон.

Л.Энхбилэг: Сая шүүхийн нээлттэй, ил тод байдлаар бол Улсын дээд шүүхийн Тамгын газрын дарга хариулчихлаа. Миний хувьд шүүх, шүүгчийн зэрэг дэвтэй холбогдуулаад хариулъя. Ганбат гишүүний асуултад хариулъя.

Тэгэхлээр Төрийн албаны тухай хуулийн 19-д бол төрийн албан хаагчид зэрэг дэвтэй байна гэсэн. 21 оны хуулиас өмнө бол шүүгч нар зэрэг дэвтэй байсан. 21 оны хуулиар шүүгчийн зэрэг дэв байхгүй. Шүүгч зэрэг дэвгүй болсон. Бидэнд одоо бол онцгой ажиллагааны, онцгой нөхцөлийн, мөн төрд ажилласан хугацааны нэмэгдэл л шүүгч нар авч байгаа. Тэгэхлээр ер нь шүүгч нар бол төрийн тусгай албан хаагч. Төрийн тусгай албан хаагчийнхаа хувьд бусад албан тушаалтнуудтайгаа адил бас тэр зэрэг дэвийг авч цалиндаа тодорхой хэмжээний нэмэгдэл авч байх ёстой гэсэн зарчмын үндсэн дээрээс зэрэг дэвийг оруулж ирж байгаа.

Тэгэхдээ бид нар зэрэг дэвийг тэр ажилласан хугацаагаар нь тухайн шатаа ажиллаж байгаа шүүгч нарыг тийм ялгамжтай байдлаар биш, адил байдлаар. Өөрөөр хэлбэл, шүүгчээр ажилласан хугацаа өөрөө албан тушаал ахихад нөлөөлдөг. 3 жил хуульчаар ажиллаж байж анхан шатын шүүхийн шүүгчээр шалгалт өгөх эрх нээгддэг. Анхан шатын шүүхдээ 6 жил ажиллаж байгаад давж заалдах шатын шүүгчийн

шалгалт өгөх эрх, мөн хяналтын шатад бол давж заалдах шатын шүүгчээр 10 жил ажиллаж байж хяналтын шатын шүүгчийн сонгон шалгаруулалтад орох ийм эрхтэй болдог. Тэгэхлээр бид бол зэрэг дэвийн тухайд төсөөлөхдөө анхан болон давах хяналт гэсэн шатлалаараа дэлхийн жишигт нийцүүлж ийм зэрэг дэвийг тогтоохоор төсөөлж байгаа.

Д.Цогтбаатар: Ганбат гишүүний микрофоныг өгье.

Д.Ганбат: Миний санасныг бодоход арай л сонин сонин л юм яриад байх юм. Одоо яая гэх вэ байгаа байдал иймээс хойш. Тэгээд яах вэ дээ ингээд нээлттэй болохоор манай шүүх ямар байгааг нь манай ард түмэн харах байх л даа. Тэр сандал, ширээ нь ямар байна, ямар шүүгч нар, ямар хэмжээнд асуудлыг шийдэж байна энэ тэр гэдэг нь.

Нөгөө тал дээр шударга үнэн бол бас хэцүү. Яг хуулийн дагуу явахад манай улс орно. Энэ хуулиуд үнэхээр арга ядаад л ингэж гаргаж байгаа хуулиуд шүү дээ. Шүүгч нартаа, шүүхдээ итгэхгүй байгаа байхгүй юу. Ийм л орчин үүсчихсэн ийм байна. Ийм болгочихсон, ингэж ойлгож байна. Энийг нь би зөв ойлгоод байна уу, буруу ойлгоод байна уу. Бусад улс оронд ийм юм байдаггүй л дээ. Манайд л ийм гажиг юм бий болчихлоо.

Шүүгч нарын хамгаалалтын асуудал гэж тавигдана. Шударга үнэн, зөвийг шийдээд байгаа, хуулийн дагуу шийддэггүй юм бол хараат бус шүүх мэдээж хэрэг бүх хүнд таалагдахгүй.

Д.Цогтбаатар: Шүүгчийн хамгаалалтын тухай ер нь ажлын хэсгээс хариулах уу? Тийм, тэгэхдээ яах вэ яг энэ хуулийн хүрээний асуудал биш ч гэсэн Тамгын газрын дарга хариулах уу? 2 дугаар микрофон.

С.Заяадэлгэр: Шүүгчийн аюулгүй байдлын хамгаалалтыг Цагдаагийн байгууллага хэрэгжүүлж байгаа. Энэ дээр өмнө нь Улсын дээд шүүхээс миний

мэдэхийн энэ хамгаалалтын асуудлыг сайжруулах чиглэлд эрх зүйн орчныг боловсронгуй болгох шаардлагатай. Өмнө Тахарын ч юм уу, маршал гэж байсан Тахарын албыг энэ мэргэшсэн чиглэлд нь ажиллуулах асуудлыг бас дэмжиж ярьж байсан. Энэ өөрөө чиг үүргийн хувьд Шүүхийн ерөнхий зөвлөл, мөн манай Дээд шүүхийн Тамгын газар энэ цагдаагийн байгууллагатай хамтран энэ чиг үүргийг хэрэгжүүлдэг байгаа.

Өнөөдөр энэ цагдаагийн байгууллагын харьяанд энэ шүүгчийн аюулгүй байдлыг хамгаалах энэ алба, нэгжийн эрх зүйн байдал, үйл ажиллагаагаа зохицуулж байгаа дүрэм, журам энэ хангалт машин техник, боловсон хүчний нөхцөл байдал бол маш олон талаар учир дутагдалтай. Сайжруулах, засах ийм асуудлууд нэлээн тулгамдсан ийм нөхцөл байдалтай байгаа. Одоо шүүгдэгчийг хуяглан хүргэх техник, тоног төхөөрөмж ч байхгүй. Ер нь бол маш хүнд нөхцөл байдалд албан үүргээ гүйцэтгэж байдаг юм байна лээ.

Цаашид энэ ил тод байдал энэ нэмэгдэх хэрээр мөн энэ асуудал ч гэсэн бас хөндөгдөж чухлаар тавигдах байх. Энэ таширамд энэ шүүхийн ил тод, нээлттэй байдлыг ханган ажиллах боломжийг олгож, энэ шүүгч нарын шүүхийн байгууллагаас гардаг энэ санаачилгыг хууль тогтоох байгууллага, ялангуяа Хууль зүйн байнгын хороо дэмжиж хүлээн авч хууль зүйн бай.../минут дуусав./

Д.Цогтбаатар: 2 дугаар микрофон гүйцээгээд хариулчихъя.

С.Заяадэлгэр: Шүүхийн ил тод байдал, түүнийг хэрэгжүүлэхэд энэ цахимжилт, боловсон хүчний, хүний нөөцийн асуудал энэ бүхнийг цогцоор нь бас шийдвэрлэхэд өнөөдрийн энэ баталж байгаа Шүүхийн хуульд орж байгаа нэмэлт, өөрчлөлт маш чухал үүрэг үүрэгтэй байгаа. Энэ манай салбарт энэ том дэвлийг хийж өгч байгаа Хууль зүйн байнгын хорооны дарга Цогтбаатар

гишүүн, хууль хамтран санаачилсан Занданшатар дарга, Учрал сайд, Хууль зүйн сайд, Байнгын олон хорооныхоо нийт гишүүдэд бас талархаж байгаагаа илэрхийлье. Цаашидынх нь ажил хөдөлмөрт бас амжилт хүсье.

Д.Цогтбаатар: Ганбат гишүүнээ ийм байгаа юм. Би ёстой танай Баянхонгор аймагт очиж ажилласан. Тэгээд шүүгчийн хамгаалалтын тухайд гэвэл эд нар байна шүү дээ ингээд санаа нь зовоод бодитоор нь бас хэлэхгүй ингээд татаж хэлээд байгаа байхгүй юу. Байхгүй, та нар байхгүй гэдгээр нь үнэнээр нь хэл. Байхгүй. Хүн амины хэрэг шийдчихээд эмэгтэй шүүгч хүнд ял оноож байгаа шүү дээ. Орой нь ганцаараа гэр рүүгээ гараад л алхаж байгаа юм. Энэ Монголын бодит амьдралын үнэн түүх. Тэнд ямар эрсдэл байгаа вэ, ямар нөхцөл байдал байгаа вэ аягүй эрсдэлтэй шүү дээ. Бас эрсдэлтэй шийдвэрүүд гаргаж байгаа. Эд нар чинь олон юм ярихгүй өдөр хоногоор байнга тэндээ бараг унтаж хоноод л бас ажиллаж байгаа. Та яг үнэн хэллээ. Шүүх ил болсноор эд нар ямар нөхцөлд ажиллаж байгааг камераар хүмүүс бас харна. Тэгэхлээр тэр үүднээсээ аягүй их хэрэгтэй.

Нөгөө талаасаа Ганбат гишүүнээ нээлттэй болгохын хувьд хоёулаа яг бодит амьдрал ярья. Сая нүүрсний хэрэг дээр Монгол Улс тэр даяараа нүүрсний хулгай хэн, юу хийчихсэн нь бүгдээрээ мэдээд байхад шүүх хуралдаан нь хаалттай яваад байгаа байхгүй юу. Бүгд мэдэж байгаа юмыг хэнээс нууж, юу хаах гээд байгаа юм. Бүүр утгагүй байдал үүсээд тэрнээс чинь болоод эд нар хаахаас өөр үггүй. Тэгээд яагаад гэвэл тэнд нь байгаа зөндөө бичиг баримтыг аваачаад Үндэсний аюулгүй байдлын нууц бичиг баримт гээд хаачихсан байгаа байхгүй юу. Тэгээд эд нар нь хаачихдаг. Олон түмэн болохлоор эд нарыг юм хийх гээд хаагаад байна гээд. Эд нар хаахыг хүсээгүй байхгүй юу. Яг энийг ингэж нэе гэдгийг шүүгчид өөрсдөө гаргаж байгаа юм. Би бас Дээд

шүүх дээр очоод ажиллахад бид нарыг энэ ялаасаа ангижруулаад өгөөч, нээлттэй бид нар хуралдмаар байна гэж байгаа байхгүй юу. Тэр нь зарчим шүү дээ.

Яагаад гэвэл Шүүхийн тухай хуульдаа энийгээ ерөнхий зарчим болгоод заачихсан. Тэр ерөнхий зарчим чинь бусад бүх юмандаа уг нь шингээд орох ёстой байхгүй юу. Монголын амьдрал юм нэг юм заачхангуутаа дандаа дараа нь ийм сиймхий олж байгаад тэрийгээ нуучихсан. Хэнд нуух хэрэгтэй байгаад байгаа юм? Хулгай хийчихсэн хүнд хулгайгаа нуухад тэрийгээ тохироод, яаж тохирч шийдвэр гаргаж байгаагаа бусдаас нуухад л хэрэг болоод байгаа юм.

Тийм учраас энэ нээлттэй зарчим нь угаасаа л хуульдаа тунхаглагдсан зарчим. Хэрэгждэггүй байсан юм байна лээ.

Ингээд зарчмын зөрүүтэй санал байхгүй байгаа. Тэгээд хуулийн төслийн одоо ингээд 1 дүгээр зүйлээр санал хураалт явуулъя.

Энэ миний машин ажиллахгүй байна шүү. Намайг санал өгснөөр бүртгээрэй.

Тэгэхлээр энэ чинь 63.3-аар санал дэмжигдэж байгаа байх. Энийгээ тооцоод манай Байнгын хорооныхон тооцоод бүүр протоколдоо оруулаарай.

Хуулийн төслийн 2 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд нэрсээ өгнө үү.

Алга байна. Зарчмын зөрүүтэй санал байхгүй. Тэгвэл ингээд 2 дугаар зүйлээр санал хураалт явуулъя. Байж байгаарай би ингэе.

Тэгэхлээр 2 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд?

Алга байна.

Зарчмын зөрүүтэй саналгүй. Ингээд Монгол Улсын Шүүхийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдтэй холбогдуулан боловсруулсан Монгол Улсын шүүхийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг явуулж дууслаа.

Хуулийн төслийн талаар зарчмын зөрүүтэй саналын томъёолол гараагүй тул хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг эцэслэн батлах үе шаттай нэгтгэн явуулах горимын саналыг дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя.

80 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Байнгын хорооны санал, дүгнэлтийг чуулганы нэгдсэн хуралдаанд Улсын Их Хурлын гишүүн Сандаг-Очир танилцуулна. Дараагийн асуудалдаа оръё.

16.09 цаг

Улсын дээд шүүх, Шүүхийн ерөнхий зөвлөл, Шүүхийн сахилгын хороо болон Хүний эрхийн Үндэсний Комиссын 2025 оны төсвийн төслийг хэлэлцье.

Монгол Улсын дээд шүүхийн 2025 оны төсвийн төслийг хэлэлцье.

Хэлэлцэж байгаа асуудалтай холбогдуулан хуралдаанд оролцож байгаа албан тушаалтнуудыг танилцуулъя.

С.Заяадэлгэр Улсын дээд шүүхийн Тамгын газрын дарга, Д.Эрдэнэчимэг Шүүхийн сургалт, судалгаа, мэдээллийн хүрээлэнгийн захирал, А.Эрдэнэцэцэг Улсын дээд шүүхийн ерөнхий нягтлан бодогч гэсэн ийм бүрэлдэхүүнтэй ажлын хэсэг хуралд оролцож байна.

Улсын дээд шүүхийн 2025 оны төсвийн төслийн талаарх танилцуулгыг Улсын дээд шүүхийн Тамгын газрын дарга Содномцэрэнгийн Заяадэлгэр танилцуулна. Заяадэлгэр даргын микрофоныг өгье. 2 дугаар микрофон.

С.Заяадэлгэр: Материал, танилцуулга дэлгэрэнгүй бүрэн эрхээр тараагдсан учраас товч танилцуулъя.

Монгол Улсын Үндсэн хуулийн 48.3-д зааснаар Шүүх улсын төсвөөс санхүүжих энэ эдийн засгийн баталгааг төр хангах, шүүхийн төсвийн төслийг боловсруулж Хууль зүйн байнгын хороогоор урьдчилан хянахтай холбоотой шүүхийн хууль тогтоомжийн дагуу өнөөдөр төслийн танилцуулгыг хийж байна.

Монгол Улсын дээд шүүхийн төсвийн төслийг боловсруулахдаа Алсын хараа-2050 бодлогын баримт бичгийн нээлттэй, ил тод, иргэн төвтэй шүүхийн зорилго, зорилтууд, мөн шүүхийн шүүх эрх мэдлийн хөгжлийн бодлого Улсын Их Хурлаар батлагдсантай холбоотой. Үүнд тусгагдсан ажлуудыг үе шаттай тусган хэрэгжүүлэх зорилтыг тавьсан.

Хяналтын шатын шүүхийн хувьд хяналтын цар хүрээ тодорхой хэмжээгээр өргөжиж байгаа. Улсын дээд шүүх дээр ирж байгаа хяналтын шатаар ирж байгаа хэрэг, маргааныг танхимын нийт шүүгчийн хуралдаанаар хэлэлцэн, мөн эндээсээ хяналтын шат руу дахин хэлэлцдэгтэй холбоотойгоор үйл ажиллагааны хуралдааны тоо хэмжээ нэмэгддэг. Мөн хуулиар тодорхойлсон албан ёсны тайлбар батлахтай холбоотой судалгаа шинжилгээний ажлуудын хэмжээ, цар хүрээ бас нэмэгдэж байгаа.

Өнгөрсөн он хугацаанд Улсын дээд шүүх 21 оны шинэ хууль хэрэгжиж эхэлснээс хойш албан ёсны хуулийг зөв хэрэглэх талаарх 14 тайлбар хэлэлцэн баталж, шүүхийн үйл ажиллагаанд нэгдмэл хэрэглээ тогтоогоод байна. Мөн

нийт шүүхийн хэмжээнд мөрдөх хуульд заасан журмуудыг хэлэлцэн баталсан.

Тухайлбал, хялбаршуулсан журмаар хэргийг хянан шийдвэрлэх, шүүх хуралдааны дэг журам болон шүүхийн шийдвэр боловсруулах аргачлал гэх мэт. Мөн Дээд шүүхийн үйл ажиллагаанд бас шинээр хэрэгжиж байгаа гол ажил бол нийт улсын хэмжээнд шүүхийн шийдвэрийг шүүгч өөрөө тайлбарлан танилцуулдаг хуулийн заалт хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор энэ ажлыг улсын хэмжээнд хэрэгжүүлэх аргачлалыг гаргаж, нэг чиглэлд оруулан ажиллаж байна.

Энэ жилийн улсын төсөвт онцлог тусгагдсан зүйл бол шүүхийн ил тод, нээлттэй байдлыг хангах, шүүхийн цахимжилтын хүрээнд тодорхой төсөв суусан байгаа. Энэ нь 5.6 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтыг төсөвлөсөн. Энэний энэ техник, тоног төхөөрөмжийн болон программ хангамжийн зардал, түрүүн хэлсэнчлэн аюулгүй байдлын асуудлууд бүхэлдээ орж байгаа. Мөн шүүх хуралдааныг нээлттэй лайв стрийм /livestream/ байдлаар дамжуулахтай холбоотой энэ зардлууд энэ хэмжээндээ багтаж орж байгаа.

Улсын дээд шүүхийн бас өмнөх ч онуудын хэмжээнээс бага хэмжээгээр 20 орчим хувиар нэмэгдсэн зардлууд гэвэл гадаад харилцааны болон сургалт, хөгжлийн арга хэмжээний зардал байгаа. Энд Улсын дээд шүүх олон улсын тавцанд үйл ажиллагаагаа нэлээд өргөжүүлж байгаатай холбоотой. Тухайлбал, Улсын дээд шүүхийн шүүгч Олон улсын эрүүгийн шүүхийн шүүгчээр сонгогдсон. Мөн Дээд шүүх одоо шүүх эрх мэдлийн бас холбогдох байгууллагуудтайгаа хамтран Европын холбооны ... хөтөлбөрийг хэрэгжүүлэхээр зорьж ажиллаж байгаа гэх мэт үйл ажиллагаанууд, мөн бүс нутгийн шүүхүүдтэй 2 талын хамтын ажиллагааг өргөжүүлэх, Ази Номхон далайн орнуудын ерөнхий шүүгч нарын

чуулга уулзалтад бас оролцох зэрэг зардлууд төсөвлөгдсөн.

Дараагийн нэг Улсын дээд шүүхийн төсөвт тодорхой хэмжээгээр өсөж орж ирж байгаа зардал гэвэл шүүхийн байр ашиглалттай холбоотой зардал байгаа.

Улсын дээд шүүхийн шүүх НИТХ-ын 2003 оны шийдвэрээр төрийн өмчит барилга үе шаттай шилжүүлэх тогтоол гарч, Хангарди ордныг шилжүүлэн авахаар шийдвэрлэсэн. Төрийн өмчийн хорооноос мөн энэ чиглэлийн шийдвэр гарч, энэ дагуу бид өнгөрсөн оны төсөвт тусгагдаж, Эдийн засгийн хөгжлийн яамнаас яамны төсөвт тусгагдсан төсвөөс зураг төслийг хийлгэсний үндсэн дээр энэ жил Хангарди барилгыг шүүхийн стандартад нийцүүлэн засах, энэ засварын ажил хэрэгжиж дууссанаар нүүж шилжихтэй холбоотой, байришхтай холбоотой, цаашид гарах ашиглалтын зардалтай холбоотой энэ хэсэг дээр тодорхой хэмжээний өсөлт гарахаар төлөвлөгдсөн байгаа.

Цалин хөлсний хувьд Засгийн газрын 2004 оны 3 сарын 27-ны өдрийн 128 дугаар тогтоол болон холбогдох шийдвэрүүдийн дагуу яг батлагдсан сүлжээгээр цалингийнхаа хэмжээг тодорхойлж оруулж ирж байгаа. Үүн дээр бол саяхан энэ Шүүхийн тухай хуульд өөрчлөлт орсноор Улсын дээд шүүхийн Тамгын газар цалингаа өөрөө тогтоодог болсон тохиолдолд энэ хэмжээг ижил төстэй байгууллагуудын хэмжээнд хүргэж өсгөх хүрээнд багахан хэмжээгээр бас цалингаа нэмэгдүүлэх ийм зорилтыг тусгасан байгаа. Энэ нь 30 хувь орчмын өсөлтийг бид нар үзэхдээ судлахдаа ижил төстэй зарим байгууллагаас 76.4 хувиар Улсын дээд шүүхийн Тамгын газрын албан хаагчдын цалин доогуур байна гэдэг ийм судалгааг хийсэн. Ингээд энийг үе шаттайгаар бас энэ зөрүүг бууруульа гэдэг үүднээс эхний ээлжид 30 хувийн нэмэгдлийг энэ төсөв дээр тусгаж орж ирээд байгаа юм.

Бусад энэ хангамж, бусад тээврийн хэрэгслийн холбогдолтой багаж, техник хэрэгсэл, бичиг хэргийн гэх мэт зардлууд бол ер нь өсөөгүй. Энэ холбогдох, тооцох ёстой тарифынхаа хэмжээнд төсөвлөн орж ирсэн болно.

Шүүхийн сургалт, судалгаа мэдээллийн хүрээлэн Улсын дээд шүүхийн дэргэд ажилладаг бөгөөд тус хүрээлэнгийн зардлыг бас Улсын дээд шүүхийн ерөнхий шүүгчийн багцад хамаарч боловсруулан оруулж ирж танилцуулсан болно.

Анхаарал тавьсанд баярлалаа.

Д.Цогтбаатар: Баярлалаа Заяадэлгэр даргад. Тэгээд Улсын Их Хурлын Тамгын газрын Хяналт шалгалт, үнэлгээний газрын Төсвийн хяналт, шинжилгээний хэлтсээс Улсын дээд шүүхийн 2025 оны төсвийн төсөлд хийсэн дүн шинжилгээний талаарх танилцуулгыг та бүхэнд хүргүүлсэн байгаа.

Ингээд Улсын дээд шүүхийн 2025 оны төсвийн төслийн урсгал зардалтай холбогдуулан асуух асуулттай гишүүд нэрээ өгнө үү.

Энх-Амгалан гишүүнээр тасаллаа. Сүхбаатар гишүүний микрофоныг өгье.

Ж.Сүхбаатар: Би яах вэ ер нь бол Дээд шүүхийнхээ болоод Шүүхийн ерөнхий зөвлөлийн гээд анхнаасаа Шүүхийн тухай хуулийн ажлын хэсгийн гишүүн байхдаа бид нар шүүхийн зардлыг нэмэгдүүлэхийн төлөө байсан хүмүүс. Хэдийгээр янз бүрийн шүүмжилдэг ч гэсэн. 2014-2022 он хүртэл шүүхийн хөрөнгө оруулалт Дээд шүүхээс бусад дээр нойл байсан шүү дээ. Тэгээд ингээд бид нэмээд 22 оноос хойш бага багаар анхаараад ингээд бас өмнөхтэйгөө харьцуулаад ахиулаад л явж байгаа. Би юм яах гэж байгаа нь нөгөө сая нэг хэсэг чинь түгжрэлтэй холбоотой ажил эрхлээд бүүр түгжрэлийн буруутан

болчихсон. 3 хоногийн дараа л бараг энэ улсын түгжрэлийн буруутан болсон шүү дээ.

Тэгээд энэ Дээд шүүх маань одоо Хангардь руу нүүж байгаа байхгүй юу. Та хэдийн яг энэ дотор дурдагдаж л байна л даа. Гарааш гээд л. Одоо ингээд ирэхээр би Заяадэлгэр даргад хэлэх гэж байгаа нь танайх тэгэхээр 292 орон тоотой байх юм уу? Одоо яг ямар орон тоотой байгаа юм? Сургалт, судалгааныхаа хүрээлэнгээ хасаад тооцвол яг хэдэн хүнтэй байгаа юм? Одоо Хангардь ордон доороо 6 машины дулаан зогсоолтой л юм байна шүү дээ.

Ингээд ирэхээр танайх чинь тэр 292 ч байна уу, ингээд 300 орчим хүн ажилладаг бол одоо Хангардь ордон руу чинь ингээд очдог, ингээд энэ Дээд шүүх чинь хэрэг шийднэ, өмгөөлөгч очно, хэргийн оролцогч нар очихгүй байлаа гэж бодоход юу гэдэг юм янз бүрийн байдлаар ингээд ирэхээр Хангардь ордон руу чинь очдог урсгал нэмэгдээд байхаар нөгөө энэ хавийн төвийн хэсгүүд ингээд улам л байгаад байгаа юм. Энэ Тагнуулын ерөнхий газар байж байна, Төрийн тусгай албан хаагчдын эмнэлэг байж байна, Их Хурал байж байна, Засгийн газар байж байна, Ерөнхийлөгч байж байна. Ингээд ерөөсөө энэ яг энэ гортиг дотор ингээд улам нэмээд байгаа юм. Тэгэхдээ арга буюу ингээд Хангардь ордон дээр бид нар шийдчихсэн.

Тэгэхээр энэ зогсоол дээр жишээлбэл ингээд засаж янзалж байгаа гэж байгаа юм. Тэгээд энэ зогсоолыг чинь жишээлбэл, яаж янзлах юм, тийм би хамгийн түрүүнд Хангардь ордон руу шилжинэ гэхэд л энэ хавийн автомашины урсгал нь юу болох юм бол доо. Дээд шүүхийн одоо байгаа байрлал ч гэсэн их эвгүй байрлалд байдаг юм шүү дээ. Чингэлтэйн тэр хавьд. Хүн амьтан яг ингээд орж гарахад аягүй төвөгтэй. Тэгээд л нэг л юм тэр. Одоо цагт чинь үйлчилгээ бол тийм болчихоод байна шүү дээ. Дандаа бүгд машинаар яваад байна, явган явахгүй байна.

Тэгэхээр энэ тал дээр нь би сая ингээд л харахад толгойд орж ирж байгаа юм тэр л байна л даа. Ингээд гарааш янзлах гэж байгаа л эд нар гэж байна. Тэр нь энэ дотроо тэгээд 6-гаа янзлаад нэмэгдүүлэх гэж байгаа юм уу? Гадна талдаа янзлаад нэмэгдүүлэх гэж байгаа юм уу? Энэ ер нь энэ чинь Хангардь ордон доороо ерөөсөө л 6 машины дулаан зогсоолтой юм уу, өөр байдаггүй юм уу? Гадаа ийм хашлага хаалт хийж байгаад хэдэн машин оруулдаг шүү дээ. Цөөхөн хэдэн машин ордог, гардаг. Тэр хавь чинь цаашаага Төв шуудан, наад талд нь баахан машин тавьдаг газруудтай. Энэтэй холбоотой, зардалтай холбоотой асуудал дээр би саяын энэ асуудал дээр ер нь яаж тооцож ингэж явж байгаа юм бол? Ер нь танайх Дээд шүүх эд нар чинь яадаг юм дундын автобус, ажилчдын автобус гэж байдаг юм уу, байдаггүй юм уу? Ингээд энгийн амьдралын хувьд харахад жишээлбэл, би бас бодохдоо ингээд л сонин л харагдаад байгаа юм л даа. Тэнд байж байх үеийн зовлон чинь энд ирээд багасаж байна уу? Ийм асуудлуудыг бас асуучих гэсэн юм. Тэр яах вэ зарим нь манайхан хянаад, тооцох юмнууд байгаа л гэж байна.

Ер нь Дээд шүүх ч тэр, Шүүхийн ерөнхий зөвлөл ч тэр ингээд хийж байгаа ажлуудаа бол ингээд сайжруулаад байгаа, ахиц гараад байгаа гэдэг юмыг Дээд шүүхийн Тамгын газар ч гэсэн ингээд хөрөнгө оруулалтууд эд нар харьцуулалтуудыг бас үзүүлж баймаар байгаа. Тэгээд манайх шүүх гэхээр шүүгч гэж ойлгоод байгаа юм. Тэр шүүх хуралдааны танхимд чинь үүдний өрөөнөөс эхлээд л заал байхгүй. Заал байхгүй. Олигтой заал байхгүй, суудал байхгүй. Хүн үйлчлэх гэж байгаа газар шүү дээ. Тэгээд л гадаа багширалдаад л. Тэгээд л энэ шүүхүүдийг ингээд харахад чинь ерөөсөө хамгийн умгар өрөөнд байдаг. Олон зуун мянган хүн үйлчлүүлдэг. Дээд шүүхээр тэгж үйлчлүүлэх бид нар хумьчихсан. Гэхдээ л

ингээд л ийм асуудлууд байгаа. Ер нь шүүгчийн ачаалал ч гэсэн ер нь яаж байна? Өмнөхөө бодвол бид нар бууруулсан л гэж ойлгоод байгаа шүү дээ.

Д.Цогтбаатар: 2 дугаар микрофон. Заяадэлгэр дарга хариулах уу?

С.Заяадэлгэр: Баярлалаа. Сүхбаатар гишүүний асуултад хариулъя. Нэгдүгээрт, Хангардь ордны зогсоол, гарааш ерөөсөө 10 машины л асуудал шийдвэрлэгдэх юм билээ. Манай одоогийн Дээд шүүхийн байгаа байрны гадна зогсоол мөн л тийм. Тэгэхээр өмнөх байдлаараа гарааш түрээслэх байдлаар бусад автомашиныхаа асуудлыг шийдвэрлэнэ л гэсэн ийм төсөв, төлөвлөгөө орж ирж байгаа.

Орон тоо нийтдээ 264 орон тоотой. Улсын дээд шүүх 25 шүүгчтэй, 239 захиргааны албан хаагчдын орон тоотой боловч 60-70 орон тоо ер нь нөхөгддөггүй. Нөгөө шүүгчийн судлаач туслах шаардлага өндөр тавигддаг учраас ер нь 75 судлаач туслах нийтдээ туслах байх байсан. Эндээс 50 нь нөхөгдөхгүй, 20 гаруй туслах судлаач тэгээд орж, гарах байдлаар явж байгаа.

Жилд цалингийн сангийнхаа 2022 онд онд бид нар 2 тэрбум гаруй тийм төгрөг хэмнэж байсан. Өнгөрсөн жил тэрбум орчим төгрөг хэмнэсэн. Угаасаа сүлжээгээрээ цалинжаад л, төсөвтөө буцаан хураагддаг байгаа. Тийм, энэ хориотой өөр зүйлд шилжүүлэн зарцуулах хориотой учраас цалин буцаад улсын төсөвтөө хураагдаад явдаг байгаа.

Д.Цогтбаатар: Энх-Амгалан гишүүн.

Б.Энх-Амгалан: Шүүхийн энэ байрны ашиглалттай холбоотой, хангамж, бараа материалтай холбоотой, эд хогшил, урсгал засвартай холбоотой тэр шүүхийн байрны дулаан халаалт ажиллах орчин тэр ширээ сандал, тэгээд тэр ариун цэврийн

өрөөнөөсөө авхуулаад дээр нь компьютер бичиг хэрэг гээд ингээд зардлууд ч энэ гол нь нэмэхээр харагдаад байдаг юм. Хаана ч очсонд яг шүүх тийм жсоохон царай муутай л байж байгаа байхгүй юу.

Тэгэхээр тэрийг жсоохон нэмэхээр байгаа юм. Энийг бол би улс анхнаасаа Шүүхийн хуулийг дэмжиж байсан. Тэгээд л энийгээ нэмэхгүй бол яаж ийм орчинд хүний хувь заяа шийдээд ажиллах вэ дээ гэдэг ийм л байр суурьтай байгаад байдаг юм. Сая оруулж ирсэн энэ төсвөөс ингээд харахаар зэрэг энэ рүүгээ юм тавиагүй хэр нь томилолтынхоо зардлыг, зочныхоо зардлыг, урамшууллынхаа зардлыг л нэмсэн харагдаад байх юм. Та хэд маань байр ашиглалттай холбоотой тогтмол зардлаа бол хасмааргүй л байсан байхгүй юу.

Энэ дээр та хэд чинь хэлж байна шүү дээ. Тэгээд яах вэ Хангардь 10 граж, зогсоолтой. Өмнө нь ч тийм байсан. Тэрүүгээрээ явчихъя гэж. Тэгвэл тэрний дулаан зогсоолын түрээсийн зардлыг хасаж яах гэсэн юм. Нэмээд л өөр газар түрээслээд л тэгээд л өвлийн хүйтэнд машин тэргээ тавиад л явна биз. Энэ дээр ингээд бууруулж тооцсон ийм мэдээлэл ороод ирж байна. Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал чинь буурчихсан. Тэгээд та хэдийн хэлж байгааг сонсохоор зэрэг багтахгүй. 10 машин л байдаг. Өмнөх шүүхийн гадаа ч гэсэн 10 машин л багтаж байсан. Тэрүүгээрээ л явах гэж байна гээд. Тэгсэн бол та нар авто зогсоолын түрээсийн зардлаа бууруулмааргүй байхгүй юу. Нэг дэх нь.

Хоёр дахь нь та хэд миний түрүүн хэлсэн зардлуудыг нэмээгүй хэр нь 2024 оны батлагдсан төсвөөсөө 11.1 хувиар нэмэгдүүлээд энэ томилолт, зочны зардлаа нэмчихсэн байгаа байхгүй юу.

Тэгээд энэ яагаад тэгж байгаа юм гэхээр та хэд маань манай шүүгч олон улсын эрүүгийн хэргийн шүүгч болсон учраас гээд. Тэр шүүгчийн цалинг

та нар төлөхгүй биз дээ энэ чинь? Олон улсаасаа авна биз дээ. Хангамж, цалин пүнлүү, нийгмийн халамж тэр юмаа олон улсынхаа байгууллагаас Олон улсынхаа эрүүгийн шүүхээс авах байлгүй дээ. Тэгэхээр зэрэг энэ бол бас л ингээд би харахад бол жсоохон нэлээн л болж өгөхгүй л юм харагдаад байх юм

Гурав дахь нь та бүхэн энэ бараа үйлчилгээний зардал. Энэ сургалт, семинар зөвлөгөөн, цахим хэлбэрээр зохион байгуулж байгаа бусад зардлаа хэмнээд тэгсэн хэр нь ажил олгогчоос олгож байгаа 1 удаагийн шагнал, урамшууллын зардлаа 2024 оны батлагдсан төсвөөсөө 13 хувиар нэмчихсэн байгаа байхгүй юу. 1 удаагийн шагнал, урамилаа нэмсэн хэр нь сургалт, семинарууд таначихсан. Уул нь ажлаа зөв явуулахын тулд, идэвхтэй байлгахын тулд хүмүүсээ сургаж, дадлагажуулж, чадавхжуулахын тулд бол сургалт, семинарынхаа зардал, энэ хурал зөвлөгөөнийхөө зардлыг уг нь бууруулмааргүй санагдах юм.

Тэгээд ингээж төсөвлөсөн 4 юмыг чинь л би харчхаад энэ үндсэн үйл ажиллагаа дээрээ цалин нэмэгдэж байгаа бол хамаа алга. Орон тоогоо бүрэн авч байгаа бол хамаа алга. Урсгал зардал, тэр байр хангамжийнхаа засвар үйлчилгээ, ажлын байрныхаа нөхцөлийг сайжруулж байгаа бол энэ ялт ч үгүй л тийм байна лээ гэхээс. Тэгэхгүйгээр нөгөө талдаа бол энэ 2 чинь ингээд урвуу хамааралтай болоод байгаа учраас л би асуугаад байна л даа. Энэ дээр хариулт өгөөдхөөч.

Д.Цогтбаатар: 2 дугаар микрофон.

С.Заяадэлгэр: Энх-Амгалан гишүүний асуултад хариулъя. Энэ нэгдүгээрт байрны түрээс, ашиглалттай холбоотой зардлууд харин ч өссөн байгаа. Тэгээд энэ Хяналт шалгалтын хэлтсээс болохоор зэрэг энэ дээр давхар энэ зардлуудыг өсгөсөн байна бууруулья гэдэг санал орж ирж байна

гэж ойлгосон. Манай хувьд бол хуучин ашиглаж байгаа байраа өөр шүүхэд ишлжүүлэх юм бол тухайн байртай холбоотой ашиглалтын зардлууд ирэх жил гарахгүй. Буурах боломжтой гэдэг байдлаар төсөвлөсөн. Хангардь барилгатай холбоотой одоо зардлыг бууруулах боломжгүй учраас тэр хэмжээгээр нь төсөвлөөд орж ирж байгаа. Энэ дээр 95 хувийн орчим хувийн өсөлт гарчхаад байгаа юм.

Хоёрдугаарт, манай энэ томилолт, гадаад орчны зардал өсөж байгаа шалтгаан бол ер нь Улсын дээд шүүхийн дэлхийн түвшинд болон бүс нутгийн хэмжээнд явуулах үйл ажиллагааны цар хүрээ нэлээн өргөжиж байгаа юм байгаа. Энэ хүрээнд бас дандаа зардал гаргаад байдаггүй, бас төсөл, хөтөлбөр хэрэгжих 1.5 сая долларын твини хөтөлбөрийг Европын холбооны тусламж авч, энэ өөрөө бас гадаад харилцаа өссөний үр дүнд орж ирж байгаа бидний бас зээл тусламж, буцалтгүй тусламж гэж ойлгож байгаа. Энэ мэт шууд болон шууд бус ач холбогдлууд маш их байгаа. Дээд шүүхийн шүүн таслах ажиллагаанаас гадна бусад үйл ажиллагаа тайлбар гаргах судалгаа шинжилгээний ажлууд энэ бүх ажлууд нэлээн ачааллын хувьд өсөж байгаа. Түрүүн ачаалал асууж байсан.

Гуравдугаарт, энэ шагнал, урамшууллын зардал болохоор нийт цалингийн сангаа дагаж өсөөд байгаа. Энэ нь өөрөө Засгийн газрын 319 дүгээр тогтоолоор өөрөө бодох хэмжээтэй тэр сангаа дагаж өсөж байгаа л өсөлт байгаад байгаа. Тэр хэмжээнд нь л тооцож оруулахаас өөр аргагүй байдаг.

Дөрөвдүгээрт, энэ компьютер, тоног төхөөрөмж болон техник, программ хангамж энэ үндсэн үйл ажиллагаагаа сайжруулах хөгжүүлэхтэй холбоотой зардлууд бол хөрөнгө оруулалтын зардал дээр тусаж орж ирсэн байгаа.

Д.Цогтбаатар: Энх-Амгалан гишүүний микрофоныг өгье, тодруулъя.

Б.Энх-Амгалан: Би энэ 25 оны төслийн хөрөнгө оруулалтын чинь зардал 5.6 тэрбум байгаа тэр чинь 51.4 хувиар буурчихсан ороод ирлээ л дээ. Улсын дээд шүүхээс ирүүлсэн төсвийн төслийн чинь санал 38.1 хувиар буурчихсан ороод ирж байгаа юм. Танай 24 онд батлагдсан төсөв 29 тэрбум байхад 25 оны чинь санал 32.8 тэрбум байна, хянасан санал нь 26.7 гээд ингээд нөгөөдхөөс чинь 8, 9 тэрбумаар доошоо буучихсан. Тэгэхээр ингээд та хэд маань энэ дээр жаахан ажиллаж энэ танагдсан төсвүүдээ эргээж оруулаач л гэж байгаа юм. Нэг дэх нь.

Хоёр дахь нь би бол тэр томилолт гэхээсээ илүү та бүхэн тэр гадаад сургалт дээрээ жоохон анхаараач. Хуульчдын холбоо, энэ Өмгөөлөгчдийн холбоо чинь энэ гадаадын энэ байгууллагуудын олон улсын сургалтад суугаад, туршилага солилцоод, яг бодитойгоор шүүх хуралд суугаад, тэгээд ингээж мэтгэлцдэг юм байна, ингээж хэргийн процесст оролцдог юм байна.../минут дуусав./

Д.Цогтбаатар: 1 минут нэмж өгье.

Б.Энх-Амгалан: Шүүхийнхэн маань болохоор зэрэг хөдлөхгүй л байгаад байдаг. Тийм учраас энэ рүүгээ явуулбал их зүгээр байх. Тэр шагнал, урамшил ч ямар байдаг юм мэдэхгүй байна. Зүгээр яг ажиллагаагаа явуулахад бол нэлээн идэвхтэй тооцох нь зөв байх. Та хэд тэр нөгөө авто зогсоолын түрээсийн зардлаа бууруулаад хэрэггүй дээ. Тэрийгээ буцааж оруулж байгаад, ядаж дахиад 10 тэрэг ч болсон өвөл тэр гарааш, дулаан гараашинд хийх түрээсийн мөнгөө хийсэн нь бол зөв байлгүй дээ. Иймэрхүү иймэрхүү юмнуудаа анхаараарай гэж би хэлэх гэж байгаа юм. Баярлалаа.

Д.Цогтбаатар: Ингээд төсвийн төслийн урсгал зардалтай холбогдуулан гишүүд асуулт асууж дууслаа.

Улсын дээд шүүхийн 2025 оны төсвийн төслийн хөрөнгө оруулалтын зардалтай холбогдуулан асуулт асуух гишүүд нэрсээ өгнө үү.

Алга байна.

Улсын дээд шүүхийн 2025 оны төсвийн төслийн хөрөнгө оруулалтын зардалтай холбогдуулан гишүүд асуулттай гишүүд алга байна.

Улсын дээд шүүхийн 2025 оны төсвийн төслийн талаарх танилцуулгатай холбогдуулан үг хэлэх гишүүд нэрсээ өгнө үү.

Энхбаяр сайдад өгье микрофон.

Б.Энхбаяр: 2000-2024 оны парламентын бүрэн эрхийн хугацаанд байгуулагдсан Хууль зүйн байнгын хорооны хамгийн сүүлийн хуралдаан болж байна. Хамгийн сүүлийн хуралдаан нь Монгол Улсын дээд шүүх, Шүүхийн ерөнхий зөвлөл, Шүүхийн сахилгын хорооны 25 оны төсвийг хянаж байна.

Төсөв дээр би тодорхой байр суурь, санал зүйл хэлэхгүй. Улсын Их Хурлаас энэ Тамгын газрын Хяналт шинжилгээ мониторингийн газраас хянасан хүрээнд нь хянасан, дэмжинэ. Шүүх эрх мэдлийн хараат бус байдал, эдийн засгийн бие даасан байдлыг хангахын тухайтад Улсын Их Хуралд сонгосон цагаасаа эхэлж ажиллаж байгаа. Шүүхийн шинэчлэл дээр, Шүүхийн хуулийн шинэчлэл дээр ч манлайлж ажилласан, бусад эдийн засгийн бие даасан байдал дээр ч гэсэн цаашид манлайлж ажиллана.

Нэг зүйлийг харин протоколд тэмдэглэж хэлмээр байна. Улс төр гэдэг өөрөө бодлогын мэтгэлцээнүүд байдаг. Энд хэн нэгэн хувь хүмүүсийн харилцаа, сайн, муугийн харилцаа гэхээсээ илүү

Үндсэн хуульд заасан хууль тогтоох, гүйцэтгэх, шүүх эрх мэдлийн институт хараат бус, бие даасан байх, бие биедээ оролцохгүй байх тэр зарчмаараа яваасай гэж хүсэж явдаг. Тэр ч утгаараа миний бие Шүүхийн хуулийн шинэчлэл батлагдсанаас хойш шүүхээр хянан шийдвэрлэгдэж байгаа хэрэг учралын тухайтад урьдчилсан байр суурь илэрхийлэх, нөлөөлөх, ямарваа нэгэн үйл ажиллагаа явуулахаас татгалзаж ирсэн. Одоо ч Хууль зүй, дотоод хэргийн сайдаар ажиллаж байгаа үедээ тодорхой хэрэг хянагдаж байгаа хэрэг учрал дээр байр суурь илэрхийлэхээс үргэлж түдгэлзэж ирж байгаа. Энэ нь бол шүүх эрх мэдэл хараат бус, бие даасан байх тэр Үндсэн хуулийн үзэл санаанд үнэнч байгаа хэрэг шүү. Шүүх эрх мэдлийн байгууллагад ажиллаж байгаа хүмүүс маань ч гэсэн энэ итгэл үнэмшлийг ойлгож, бас зарчмаа барьж ажиллаж байгаасай гэсэн ийм хүсэлт байна.

Өнгөрсөн хугацаанд нүүрсний сонсгол хийгдсэний ар дээр Монгол Улсын Шүүхийн ерөнхий зөвлөлд удирдах албан тушаал хашидаг албан тушаалтан өөрийн хувийн социал хаяг дээрээ нүүрсний хулгайчийг өмгөөлж нүүрсний сонсголыг ахалж ажилласан миний биеийг буруутгасан пост хийж байсан. Би энийг ил хараад өнгөрч байсан. Төрийн тусгай албан хаагч. Тэр дотроо Монгол Улсын Шүүхийн ерөнхий зөвлөлд ажиллаж байгаа хүн тодорхой ийм асуудал дээр олон нийтэд хувийн танил талаа өмгөөлж, тэр тусмаа хулгайчаар цоллогдсон хүнийг өмгөөлж байгаа нь маш их сонирхлын зөрчилтэй санагдсаныг нуух юун.

Тийм учраас энэ асуудал дээрээ ялангуяа шүүх эрх мэдэлд удирдах албан тушаал хашиж байгаа хүмүүс байр сууриа илэрхийлэх дээрээ анхаарч ажиллаасай гэсэн ийм хүсэлт байна.

Миний бие шүүх эрх мэдлийн байгууллагад хийгдэж байгаа ямарваа томилгоонд хөндлөнгөөс оролцдоггүй.

Шүүх эрх мэдлийн байгууллагад ажиллаж байгаа хүмүүс ч гэсэн Хууль зүй, дотоод хэргийн сайдын хуулиар хүлээсэн чиг үүргээ хэрэгжүүлэх томилгоонд оролцож, олон нийтийн сүлжээнд байр суурь илэрхийлдгээ таслан зогсоовол зохино. Цагдаагийн байгууллагын удирдах албан тушаалтанд хууль ёсны хариуцлага тооцсоныг өмгөөлж Хууль зүйн сайдыг буруутгасан постуудыг Улсын дээд шүүх болон, Шүүхийн ерөнхий зөвлөлийн удирдах албан тушаалтнууд нийгмийн сүлжээнд хувийн хаягуудаараа дамжуулж илэрхийлсэн. Та бүхэн тэрүүгээрээ бие биеийгээ таньдаг, ойр дотно байх чинь энд падгүй шүү. Та бүхэн улс төрөөр оролдох гэж байгаа бол улс төр та бүхнээр оролдоно. Зүгээр хараад суухгүй шүү гэдгийг би протоколд зориуд тэмдэглүүлж хэлье.

Д.Цогтбаатар: Ингээд төсвийн төслийн талаарх танилцуулгатай холбогдуулан үг хэлэх гишүүд үг хэлж дууслаа.

Саналтай гишүүн байхгүй байгаа. Энэ дээр тэгэхлээр санал хураана. Санал хураахдаа энэ оруулж ирсэн саналаар нь өөрөөр хэлбэл, 32.8 тэрбумаар энэ төслийг нь дэмжье гэсэн томъёоллоор санал хураамаар байна. Тэгээд энэ дээр нь би томъёоллыг нь уншаад өгчихье.

Улсын Дээд шүүхийн 2025 оны төсвийн саналыг хасагдуулахгүйгээр Төсвийн ерөнхийлөн захирагчид хүргүүлэхийг дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя.

Санал хураалт 54.5 хувиар санал дэмжигдлээ.

Одоо ганц, хоёр санал байгаа шүү гишүүд ээ байж байгаарай.

Ингээд Улсын дээд шүүхийн 2025 оны төсвийн төслийг хэлэлцэж дууслаа. Дараагийн асуудалдаа оръё.

Хүний эрхийн Үндэсний Комиссын 2025 оны төсвийн төслийн талаар хэлэлцье.

Хэлэлцэж байгаа асуудалтай холбогдуулан хуралдаанд оролцож байгаа албан тушаалтнуудыг танилцуулъя.

Хүний эрхийн Үндэсний Комиссын дарга Сүнжид, Хүний эрхийн Үндэсний Комиссын Тамгын газрын дарга Адъяахишиг, Хүний эрхийн Үндэсний Комиссын нягтлан бодогч Бадамсэрээжид гэсэн бүрэлдэхүүнтэй ажлын хэсэг оролцож байна.

Хүний эрхийн Үндэсний Комиссын 2025 оны төсвийн төслийн талаарх танилцуулгыг Хүний эрхийн Үндэсний Комиссын дарга Дугарын Сүнжид уншиж танилцуулна. Сүнжид даргын микрофоныг өгье. 5 дугаар микрофон.

Д.Сүнжид: Эрхэм хүндэт Хууль зүйн байнгын хорооны дарга, эрхэм хүндэт Хууль зүйн байнгын хорооны гишүүд ээ,

Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хуулийн 6.1 дэх хэсэгт заасны дагуу Хүний эрхийн Үндэсний Комиссоос жилийн төсвийн төслийг төлөвлөн Хууль зүйн байнгын хорооны хуралдаанд хэлэлцүүлэхээр 5 дугаар сарын 7-ны өдөр Улсын Их Хурлын даргад хүргүүлсэн болно.

Комисс нь Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хуульд заасан үндсэн чиг үүргийг хэрэгжүүлдэг. Түүнээс гадна бусад хуулиудаар нэмэлт чиг үүргүүдийг хэрэгжүүлж байна. Энэ дээр Жендерийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулиар тодорхой хяналт шалгалт хийх, Улсын Их Хуралд илтгэлийг 2 жил тутамдаа өргөн барих ийм үүргийг хүлээж байна.

Хүний эрх хамгаалагчийн эрх зүйн байдлын тухай хуульд заасны дагуу жил болгон илтгэлдээ хүний эрх хамгаалагчийн эрх зүйн байдлын талаар

тодорхой асуудлыг сонгон авч, асуудлыг хяналт шинжилгээ, үнэлгээ хийн судлах, илтгэх энэ үүргийг хүлээж байна. Хүний хувийн мэдээллийг хамгаалах тухай хуульд зааснаар зөрчилд хяналт тавих, зөрчлийн бүртгэл хийх, нэгдсэн сан үүсгэх, холбогдох журам санал өгөх, өөрийнхөө санал санаачилгаар шалгаж шийдвэрлэх, холбогдох байгууллагад шаардлага, зөвлөмж хүргүүлэх гээд ийм үүргийг хүлээж байна.

Хүүхдийн эрхийн тухай хуулиар мөн хүүхдийн эрхийг зөрчсөнтэй холбоотой гомдлыг хүлээж авч, хянан шийдвэрлэх үүрэг хүлээж байна. Хөдөлмөрийн тухай хуульд зааснаар ажил эрхлэлт хөдөлмөрийн харилцаанд ялгаварлан гадуурхсан гэж үзсэн ажилтан, ажилтны төлөөллийн гомдлыг хүлээж авч хянан шийдвэрлэх юуг хүлээж байна. Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуульд зааснаар мөн гаргасан гомдлыг хүлээж авч, шалган шийдвэрлэх ийм үүргийг хүлээж байна. Энэ Үндсэн хууль Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хуульд заасан чиг үүргээс гадна ингээд нэмэлт 6 хуульд заасан тусгайлсан чиг үүргийг давхар хэрэгжүүлж байгаа болно.

Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хуулийн 6.3-д Комисс өөрийн үйл ажиллагаагаа явуулах байртай байна гэж заасан байдаг. Ингээд байгуулагдсанаасаа хойш 23 жилийн хугацаанд яг өөрийн байргүй, түрээсээр Засгийн газрын байранд үйл ажиллагаагаа явуулж байна.

Алсын хараа-2050 бодлогын, урт хугацааны бодлогын баримт бичгийн 5.5.1, 5.5.2, Хөгжлийн зорилтод хөтөлбөрийн 4.2.14-д хүний эрхийг хангах тогтолцоог бэхжүүлнэ. Энэ хүний эрхийн үндэсний байгууллагыг бэхжүүлнэ гэдэг энэ зорилтуудыг тус тус дэвшүүлсэн байдаг.

Монгол Улсын Их Хурлаас 2023 оны 12 дугаар сарын 22-нд Хүний эрхийн түгээмэл тунхаглал батлагдсаны 75

жилийн ойд зориулаад 114 дүгээр тогтоол гаргасан. Энэхүү тогтоолын 2-ын Г хэсэгт Нэгдсэн үндэсний байгууллагын харьяа Ази Номхон далайн бүсийн төвийг Монгол Улсад байгуулах санаачилга гаргаж шийдвэрлүүлэхийг Засгийн газарт даалгасан.

Засгийн газраас хүний эрхийн түгээмэл тунхаглал 75 гээд дээд хэмжээний арга хэмжээнд оролцохдоо Нэгдсэн үндэсний байгууллагуудын өмнө энэ дээр Нэгдсэн үндэсний байгууллагын Хүний эрхийн бүсийн сургалт, судалгааны төвийг Монгол Улсад байгуулах талаар санаачилгаа бас танилцуулсан байгаа.

Үүнээс гадна Хүний эрхийн Үндэсний Комисс бүс нутгийнхаа чуулганд идэвхтэй оролцдог. Энд 2001 оноос хойш гишүүн байгаа статустайгаар итгэмжлэгдсэн. Энэхүү Ази Номхон далайн чуулганы 5, 10 дахь ээлжит хурал, 20 дахь ээлжит хурлыг Монгол Улс урьж зохион байгуулж байсан уламжлалтай. Одоо энэ 30 дахь ээлжит хурал нь 2025 онд зохион байгуулагдана. Уламжлал ёсоороо Монгол Улс хүлээж авч, энэхүү хурлыг зохион байгуулах, манлайлах энэ санаачилгыг мөн илэрхийлээд байгаа. Төсөв дээр энэнтэй холбоотой бас нэмэгдэл дагаад ийм саналууд орж ирж байгаа.

Ингээд Хүний эрхийн Үндэсний Комиссын төсвийн төсөл нь Алсын хараа-2050 Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын 8-н зорилго, зорилт, Хөгжлийн зорилтот хөтөлбөрийн 10-н зорилт, Монгол Улсыг 21-25 онд хөгжүүлэх 5-н жилийн үндсэн чиглэлийн 2 зорилго, зорилтуудтай уялдуулаад нийтдээ 2025 онд 30 тэрбум 603 сая 200 мянган төгрөг байхаар төлөвлөн танилцуулж байна.

Эндээс үндсэн чиг үүргээ хэрэгжүүлэхтэй холбоотой 12 тэрбум 207 сая 500 мянган төгрөг байхаар, өмнө дурдсанчлан Хүний эрхийн Үндэсний

Комиссын байр, Ази Номхон далайн бүс нутгийн сургалт, сурталчилгааны төв байгуулахтай холбоотой зардал 18 тэрбум 395 сая 700 мянган төгрөг байхаар тоочлоо.

Цалин хөлс, нэмэгдэл урамшууллын зардлын хувьд орон тоо нь 82 цалингийн төсвийн сантай яваа. Батлагдсан бүтцийн хувьд 98 байгаа. Энийг нэмэгдэх 16 орон тоо нь хүний эрх хамгаалагч, эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх, хүний хувийн мэдээлэл хамгаалах гээд энэ 3 нэмэлт чиг үүрэг хэрэгжүүлэх механизмтай холбоотой орон тоонууд нэмэгдэж байгаа. Мөн Засгийн газрын 24 оны 82, 83 дугаар тогтоолын дагуу орон нутагт ажиллаж байгаа 21 аймгийн референтүүдэд сар болгоны нэмэгдэл болоод, тодорхой 5-аас дээш жил ажилласан бол мөнгөн урамшуулалд хамрагдана гэдэг энэ мөнгийг тооцоолохоор ийм нийтдээ үнийн дүн ийм байдлаар гарч байна.

Эрхэм хүндэт Хууль зүйн байнгын хорооны дарга, эрхэм хүндэт Хууль зүйн байнгын хорооны гишүүд ээ,

Хүний эрхийн чиглэлээр бие даасан хараат бус байх чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг хуульдаа заасан 11 төрлийн чиг үүргийг хэрэгжүүлдэг Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын төсвийн ерөнхийлөн захирагчийн 25 оны төсвийн төслийг хэлэлцэн дэмжиж өгөхийг та бүхнээс хүсье.

Асуулт байвал, тодруулах зүйл байвал хариулахад бэлэн байна.

Д.Цогтбаатар: Улсын Их Хурлын Тамгын газрын Хяналт шалгалт, үнэлгээний газрын Төсвийн хяналт, шинжилгээний хэлтсээс Хүний эрхийн Үндэсний Комиссын 2025 оны төсвийн төсөлд хийсэн дүн шинжилгээний талаарх танилцуулгыг та бүхэнд хүргүүлэн тараасан байгаа.

Хүний эрхийн Үндэсний Комиссын 2025 оны төсвийн төслийн урсгал

зардалтай холбогдуулан асуух асуулттай гишүүд нэрээ өгнө үү.

Сүхбаатар гишүүнээр тасаллаа. Мөнхцэцэг гишүүний микрофоныг өгье.

Ц.Мөнхцэцэг: Тэгэхээр өнгөрсөн хугацаанд Улсын Их Хурал дахь хүний эрхийн дэд хорооны даргын хувьд, Хүний эрхийн Комисстой бас нэлээн ойр ажиллаж тодорхой асуудлууд дээр, тодорхой кэйсүүд дээр бас хамтран хяналт шалгалт хийсэн. Эндээс ингээд харахад яг энэ манай Хүний эрхийн Комиссын дотоод томилолтын буюу яг тухайн хүний эрхийн зөрчил гарсан асуудлууд дээр очиж ажиллах энэ зардлыг бол ихээхэн нэмэх шаардлага байна.

Тэгээд Улсын Их Хурал дээр хүний эрхийн дэд хороонд ирж байгаа бас нэлээд олон гомдлууд бас хөдөө орон нутаг болон зайлигүй хүрч очих шаардлагатай маш их ирж байна. Тийм учраас энэ дотоод томилолтын зардал буюу яг тэр хүний эрхийн зөрчил гарсан хэсэгт очиж ажиллах, хүний эрхийн зөрчигдсөн эрхүүдийг нөхөн сэргээх тухайд зардлууд нь хэр нэмэгдэж байгаа вэ гэдгийг асуумаар байна.

Хоёрдугаарт нь ер нь энэ нийгэм дэх хүний эрхийн боловсролыг дээшлүүлэх, тэр дотроо төрийн янз бүрийн байгууллагууд, хууль сахиулах байгууллага, хүчний байгууллагууд, зэвсэгт хүчин зэрэг энэ тодорхой хүний эрхийн зөрчил ихээхэн гарч байгаа байгууллагуудын албан хаагчид, ажилтнуудад хүний эрхийн боловсрол олгох буюу нөлөөллийн ажлын зардлууд ер нь нэмэгдэх шаардлагатай байдаг.

Тэгээд энэ Хүний эрхийн Комиссын 2025 оны төсөвт хийсэн манай аудитын юуны дүгнэлтийг ингээд харахаар ерөнхийдөө энэ бусдаар гүйцэтгүүлэх ажлын зардал нэлээн өссөн харагдаж байгаа юм. Тэр дотор нь судалгааны ажил гүйцэтгэх гээд. Яг нөгөө нийгэм дэх энэ нөлөөллийн

чиглэлийн, хүний эрхийн боловсролын чиглэлийн төсөв маань хэр нэмэгдэж байгаа вэ? Энэ тал дээр ямар юмнууд хийхээр байна? Сая ингээд харж байхад хүүхдийн баяраар Хүний эрхийн Комисс анх удаагаа хүүхдүүдэд зориулсан хүний эрхийн, хүүхдийн эрхийн өдрийн хөөрхөн марафон хийж бас хүүхдүүдэд хүний эрхийн чиглэлийн нөлөөллийг хийсэн байна. Энэ мэтээр хүүхдүүд, ерөнхий боловсролын сургууль, оюутан сурагчид зэрэг гол ирээдүй үеийнхэнд зориулсан нөлөөллийн ажлууд дээр ер нь ямаршуу төсөв тавигдаж байгаа вэ?

Гуравдугаарт нь яг энэ хууль, шүүхийн газрууд буюу ер нь хууль сахиулах орчинд хүний эрхийн зөрчил хамгийн их гарч байна. Энэ тал дээр гомдол их ирдэг. Тэгэхээр энэ прокурор, хууль сахиулах байгууллагуудтай хэрхэн хамтран ажиллах энэ энэ тал дээр хийх ажлууд дээр ер нь төсөв, зардал маань нэмэгдэж байгаа юм уу гэдэг ийм 3 зүйлийг тодруулъя.

Д.Цогтбаатар: 4 дүгээр микрофон өгье.

Ц.Адъяахишиг: Бүхэнд өдрийн мэнд хүргэе.

Хүний эрхийн Үндэсний Комиссын Тамгын газрын дарга Адъяахишиг. Мөнхцэцэг гишүүний хариултад асуултад хариулъя.

Хүний эрхийн Үндэсний Комиссын дотоод томилолттой холбоотой зардлыг энэ 2025 онд бол бид нар 174 сая төгрөгөөр бол нэмэгдүүлж орж ирж байгаа. Энэ нэмэгдэж байгаа зардал маань бол энэ жилийн зардлын, энэ жил бол дотоод томилолтын зардлын үнэ тариф нэмэгдсэнтэй холбоотой тодорхой зардлууд нэмэгдэж байгаа.

Үүнээс гадна хичээл сургалт, үйлдвэрлэлийн зардал дээр бид нар судалгааны ажлын зардлыг бол оруулж ирсэн. Өмнөх жилүүдэд бол Комиссын судалгааны ажлын зардлуудыг бид нар

олон улсын байгууллагуудын тусламж, дэмжлэгтэйгээр зохицуулж ирсэн. Энэ удаад бол бид нар 8 судалгааг 1-ийг нь 80 сая төгрөгөөр буюу ингээд 480 сая төгрөгөөр судалгаа хийнэ гэсэн байдлаар бол энэ төсөв дээр бол төлөвлөсөн.

Үүнээс гадна Комиссын сургалт сурталчилгаа, нөлөөллийн үйл ажиллагааны зардал бол өмнөх жилүүдээс бол 565 сая төгрөг байхаар бид төлөвлөж орж ирсэн. Энэ дээр Комиссын үйл ажиллагаанаас гадна шинээр бий болсон хүний эрх хамгаалагчийн, хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай, эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх энэ механизмуудын үйл ажиллагааг олон нийтэд хүргэж, танилцуулга хүргэхэд чиглэсэн зардлуудыг тусгасан байгаа болно.

Б.Энх-Амгалан: Баярлалаа. Сүхбаатар гишүүний микрофоныг өгье. Сүхбаатар гишүүн асуултаа асууя.

Ж.Сүхбаатар: Энэ нөгөө яах вэ зардал нэмэгдсэн гээд ингээд энд харагдаж байгаа боловч төгсгөлд нь хөрөнгийн зардал нэмэгдсэн л байна л даа. Энхтайван найрамдлын ордныг худалдаж аваад 15 тэрбум төгрөгөөр юм шиг байна. Худалдаж аваад ингээд их засвар хийгээд орох тухай. Ямар ч байсан Хүний эрхийн Үндэсний Комисс өөрөө ингээд биеэ даасан байртай болоод тэр Азийн хүний эрхийн төв ч билүү энэ янз бүрийн бүс нутгийнхаа хэмжээнд, олон улсын хэмжээнд бас ингээд биеэ даасан байгууллага явуулъя гээд манай эрх баригч энэ Монгол ардын нам ер нь энийг нэлээн ярьсан шүү дээ хүний эрхийн асуудлыг.

Тэгэхээр энэ Энхтайван найрамдлын ордон чинь ТББ байна уу, хувь хүний нэр дээр байсан юм уу? Засаг төрийн энд данс дээр байсан юм уу? Би энийг чинь хуучин Монголын Үйлдвэрчний эвлэл, залуучуудын байгууллага гэдэг шиг ингээд л ийм нийгэмлэгт байж байсан ийм л зүйл гэж бодоод байгаа шүү дээ.

Тэгэхээр энэ хэнээс худалдаж аваад ийм хэмжээний мөнгө нь гараад ингээд явчлав тийм ээ? Тэгээд энэ өртөг нь яаж үнэлэгдсэн юм бол доо? Ер нь миний бодож байгаа юм Хүний эрхийн Үндэсний Комиссын тэр ялалтын өндрийн тэр манай Засгийн газрын 11 дүгээр байран дээр байдаг чинь бол нэлээн жижиг талбайтай, хүн орж гарахад их төвөгтэй. Тэр Энхтайван найрамдлын ордныг ямар шалгуураар яг энэ ордон ингээд байна гэж ингээж шийдсэн юм?

Тэгээд бусад байгууллага, Засгийн газраас зөвлөсөн юм уу, та хэд юм уу, ямар юм? Энийг яаж? Бусад талаараа би дэмжиж байна. Тэр дотоод томилолтоо нэмэгдүүлэх хэрэгтэй, гадаад томилолтоо нэмэгдүүлэх хэрэгтэй. Ер нь энэ чинь өөрөө салбар байгууллагагүй газар шүү дээ. Хүний эрхийн хамгаалагчийн хууль гарчихсан. Ер нь энэ ардчилал гэдэг чинь өөрөө зардалтай эд. Дандаа зардалтай эд. Ардчилал гэдэг өртөгтэй. Өртөг зардал гарч байж юм хийдэг. Зүгээр мөнгө гаргахгүйгээр хүний эрх хамгаалаад явна гэдэг байхгүй.

Тэгэхдээ нөгөө юуны хувьд бол их анхаарах ёстой шүү. Сургалт, сурталчилгааны асуудлууд их чухал байдаг. Одоо чинь энэ цаг үеийн 21 дүгээр зууны нэг зовлонтой юм нь юу юм гэхээр зэрэг нөгөө руль булаацалдаад байна гэдэг шиг байгууллагын тодорхой байж байгаад өөрсдөө хариуцлага хүлээхгүй мөртөө яг цахимаар чинь дамжаад одоо ингэ, одоо ийм болж байна, тэгж байна гээд ингээд зэрэгцээд яваад байдаг. Яг ийм үед төрийн байгууллагууд өөрийнхөө удирдлагыг авч явж олон нийтийн санаа бодолд өөрийнхөө юмыг хүргэхэд төвөгтэй нөхцөлд орж ирж байгаа.

Яагаад гэвэл шахалтууд их оролцоо, их хөндлөнгийн оролцоо, шахалтууд их нэмэгдээд оролцогч талууд их болчихдог. Тэгэхээр тэр төрийн байгууллагуудын ажлын орчиндоо аягүй

төвөгтэй байдлууд үүснэ. Өөрийнхөө яг баримталж байгаа, тэр хийх гэж байгаа ажлаас илүү цаг үеийн асуудлуудад хөтөлөгдөөд тодорхой кэйсүүдтэй ноцолдоод явчихдаг.

Тэгэхээр энэ асуудлууд ингээд харахад байж байгаа учраас ялангуяа Хүний эрхийн Үндэсний Комиссын ажлуудын ажил байдлын тодорхой жанжин шугам дээр нь бол тухайн жилүүд дээрээ их сайн ойлгуулж явмаар. Бид энэ чиглэл рүү. Тэрнээс хүний эрхтэй холбоотой кэйс болгон, хүний эрхтэй холбоотой тодорхой асуудал болгон руу ингээд татан оруулахыг юу гэдэг юм тодорхой нийгмийн бүлгүүдийн энэ шахалтууд шүү дээ өөрсдөө. Тодорхой бүлэг болгон өөрийнхөө эрхийг хамгаалах гэж байгаа учраас шахалт үзүүлдэг. Энэ бол угаасаа ардчилал.

Тэгэхээр энэ тал дээр эд нар ч гэсэн ингээд юм хумаа, чадавхаа сайжруулах ёстой юм шиг байгаа юм. Ингээд л бид хэд төрийн байгууллагад ажиллаж байгаа бид хэдийн чинь зовлон байна шүү дээ энэ мэдээллийн зах зээл дээр мэдээллийг өгөхдөө бол өөрсдийнхөө яг ажлын чиг үүргийн дагуу хийж байгаа юмаа яаж ойлгуулах вэ гэдэг аягүй төвөгтэй. Тэгээд л нөгөө талаас нь ингээд л сэвнэ гэж хэлдэг. Нэг хэсэг бүлэг улсууд нийлээд л мэдээллээ явуулчихаар тэрэнд нь төрийн байгууллагын ажил татагдан ороод л ингээд явчихдаг.

Тэгээд энэ 21 дүгээр зууны нэг зовлонтой асуудал дотор хамгийн гол анхаарах юм бол энэ мэдээллийн урсгал дотор яаж өөрсдийнхөө ажлыг ингээж ойлгуулж явж, энийгээ барьж явах вэ гэдэг асуудал байгаа. Энэ бол Хүний эрхийн үндэсний Комиссын хувьд их чухал юм шиг байна лээ. Одоо бүх юмны бай бол Хүний эрхийн Үндэсний Комисс болчихоод байна шүү дээ. Хүний эрх нь зөрчигдлөө гэхэд л тэр байгууллага юм уу, хувь хүнд биш тэр байгууллага нь л ажлаа хийхгүй байгаа юм шиг л юм. Гэтэл.../минут дуусав./

Д.Цогтбаатар: 5 дугаар
микрофон.

Д.Сүнжид: Сүхбаатар гишүүний асуултад хариулъя. Байрны асуудал дээр ахуй ялт ч үгүй л шийдэх ёстой л асуудал болдог юм байна. Тэгээд энэ Энхтайван найрамдлын ордон Нийгмийн даатгалын ерөнхий газар, Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газар, Капитал банкны өрөнд хүлээж авсан ийм барилга юм байна. Тэгээд Засгийн газарт бид нар энийг шилжүүлж авъя гэдэг хүсэлтийг уламжилсан.

Тэгэхээр төсөвт нөгөө мөнгө нь шийдэж байж энэ асуудлыг шийдэх боломжтой байгаа юм гээд одоогийн байдлаар бол балансаас балансад шилжүүлэх боломжгүй өрөнд авсан учраас тодорхой энэ 14 тэрбумын үнэлгээтэй, 14 тэрбум 200 сая төгрөгийн үнэлгээтэй, засвар хийвэл 3 тэрбум төгрөг гарна. 3054 ийм метр квадрат 3 давхар барилга байна гээд энэ мэдээллийг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам, Нийгмийн даатгалын ерөнхий газар, Төрийн өмчийн барилга, зохицуулалтын газраас авсан. Тэгээд Засгийн газарт энэ саналыг уламжилж байгаа. Тэгэхээр төсвийн асуудлыг шийдвэрлэх шаардлагатай гэдэг ийм процесс үйл ажиллагаа үргэлжилж байгаа.

Хоёр дахь саналын тухайд мэдээллийн урсгалыг зохицуулах ялангуяа Хүний эрхийн Үндэсний Комиссын хувьд тулгардаг сорил юу вэ гэхээр иргэдэд хандаж бид нар мэдээлэл өгөх үүрэгтэй. Түүнээс гадна төрийн албан хаагчид яг тодорхой энэ хүний эрхийг түгээх, хүний эрхийн талаар ойлголт өгөх, бодлого төлөвлөх, шийдвэр гаргах, энэ албан хаагчид бас зориулаад тодорхой салбар салбараар бид нар бас энэ ойлголтыг түгээн дэлгэрүүлэх, төвшүүлэх, сургагч багш бэлтгэх, давтан сургах энэ ажлыг хийх ёстой учраас энэ дээр бол энэ тодорхой зардлын асуудлыг бид нар шийдэж байж тэр иргэний нийгмийн зөвлөл, сургагч багш, мэдээллийн компани ажлууд үнэхээр үр дүнтэй энэ

олон сувгаар яг иргэддээ хүрэхээр ийм ерөнхий байдлаар биш, албаны үг хэллэгээр биш, мэдээллийн урсгалыг менеж хийе гэвэл, зохион байгуулъя гэвэл бид нарт үнэхээр тийм олон мэргэжлийн зөвлөгөө хэрэгтэй. Тэн дээр тодорхой зардлуудыг энэ жил тусгаад тавьсан байгаа.

Д.Цогтбаатар: Хүний эрхийн Комиссын 2025 оны төсвийн төслийн урсгал зардалтай холбогдуулан гишүүд асуулт асууж дууслаа.

Хүний эрхийн Үндэсний Комиссын 2025 оны төсвийн төслийн хөрөнгө оруулалтын зардалтай холбогдуулан асуулт асуух гишүүд нэрсээ өгнө үү.

Байхгүй байна.

Хүний эрхийн Үндэсний Комиссын 2025 оны төсвийн төслийн хөрөнгө оруулалтын зардалтай холбогдуулан гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа.

Ингээд Хүний эрхийн Үндэсний Комиссын 2025 оны төсвийн төслийн талаарх танилцуулгатай холбогдуулан үг хэлэх гишүүд нэрсээ өгнө үү.

Алга байна.

Хүний эрхийн Үндэсний Комиссын 2025 оны төсвийн төсөлтэй холбогдуулан саналтай гишүүд байна уу?

Байхгүй байна.

Тэгэхлээр энэтэйгээ холбогдуулаад санал хураалт явуулна. Санал хураалтыг томъёоллыг уншиж танилцуулъя.

Хүний эрхийн Үндэсний Комиссын 2025 оны төсвийн төслийн саналыг бууруулахгүйгээр Төсвийн ерөнхийлөн захирагчид хүргүүлэхийг дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя.

Харин тийм тийм шүү дээ итгээд.

54.5 хувиар санал дэмжигдлээ.

Гэхдээ энэ дээр нэг зүйлийг тодотгож протоколд хэлмээр байна. Энэ төсвийн хүрээний мэдэгдэл Улсын Их Хурлаар батлагдана. Тэгэхлээр энэ дээр нөгөө байрны асуудал тэр Засгийн газарт хэлэлцэгдсэнээр энэ дээр засвар хийгдэж орно шүү гэдэг ойлголттойгоор бид нар энийг ингээд баталж өглөө. Энэ тэгэхлээр Засгийн газраас гарах шийдвэртээ уялдаж, тэрэнтэйгээ нийцэж төсвийн дүнд өөрчлөлт орно шүү гэдэг ийм ойлголттойгоор дэмжиж шийдвэрлэлээ.

Одоо хоёр байгууллага тэгээд дууслаа. Одоохон дууслаа шүү. Одоо дараагийн асуудалдаа орё

Шүүхийн ерөнхий зөвлөлийн 2024 оны төсвийн төслийн талаар хэлэлцье.

Хэлэлцэж байгаа асуудалтай холбогдуулан хуралдаанд ороцож байгаа албан тушаалтнуудыг танилцуулъя. Тэгж болохгүй төсөв юм чинь.

Шүүхийн ерөнхий зөвлөлийн дарга Энхбилиг, Шүүхийн ерөнхий зөвлөлийн гүйцэтгэх нарийн бичгийн дарга Эрдэнэтулга, Шүүхийн ерөнхий зөвлөлийн Санхүү, хөрөнгө оруулалтын газрын дарга Наранбилиг. Ийм бүрэлдэхүүнтэй ажлын хэсэг ороцож байна.

Шүүхийн ерөнхий зөвлөлийн 2025 оны төсвийн төслийн талаарх танилцуулгыг Шүүхийн ерөнхий зөвлөлийн дарга Лхагвадоржийн Энхбилиг танилцуулна. Энхбилиг даргын микрофоныг өгье. 4 дүгээр микрофон.

Л.Энхбилэг: Гишүүддээ үдийн мэнд. Шүүхийн ерөнхий зөвлөл 2025 оны төсвийн хязгаарын саналаа ирүүлсэн. Шүүх байгуулах тухай хууль шинэчлэн батлагдсан Монгол Улсын шүүхийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт орсон

болон Монгол Улсын нэгдсэн төсвийн 2025 оны төсвийн хүрээний мэдэгдэл батлагдсантай холбогдуулан Монгол Улсын Шүүхийн тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.8.1 дэх заалтад заасны дагуу Шүүхийн ерөнхий зөвлөлийн төсвийн ерөнхийлөн захирагчийн үйл ажиллагааны болон хөрөнгө оруулалтын 2025 оны төсвийн хязгаарын санал, 2025, 2026 оны төсвийн төсөөллийн саналыг шинэчлэн хавсралтаар хүргүүлж байна.

Мөн Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.3.1 дэх заалтад төсвийн ерөнхийлөн захирагч дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдэлд суурилсан жилийн төсвийн хязгаарын саналаа санхүү төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага жил бүрийн 6 сарын 10-ны дотор хүргүүлнэ гэж заасны дагуу Сангийн яаманд хүргүүлсэн болно.

Шүүхийн ерөнхий зөвлөлийн даргын 2025 оны төсвийн хязгаарын саналын танилцуулгаа үндэслэлээ танилцуулъя. Хууль зүйн үндэслэл нь бол Шүүхийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.6 дахь хэсэгт шүүх бие даасан төсөвтэй байх бөгөөд шүүхээс үйл ажиллагаа тасралтгүй явуулах нөхцөлийг төр хангана.

Шүүхийн төсвийн урсгал зардлын хэмжээг төсвийн хэмнэлтээс бусад тохиолдолд өмнөх жилийнхээс бууруулахыг хориглоно. Мөн хуулийн 74 дүгээр зүйлийн 74.1.1 дэх заалт Улсын дээд шүүхээс бусад шүүхийн үйл ажиллагааны болон хөрөнгө оруулалтын төсвийг төсвийн тухай хууль тогтоомжид нийцүүлэн боловсруулж, энэ хуулийн 46.8-д заасан журмын дагуу хүргүүлэх. Мөн хуулийн 46.46 дугаар зүйлийн 46.8.1 дэх заалт Улсын дээд шүүх өөрийн Ерөнхий зөвлөл, Улсын дээд шүүхээс бусад шүүхийн үйл ажиллагааны болон хөрөнгө оруулалтын төсвийг төлөвлөн Байнгын хороонд хянуулахаар хүргүүлэх.

Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.3 дахь заалт Төсвийн ерөнхийлөн захирагч дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдэлд суурилсан жилийн төсвийн хязгаарын саналаас санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад жил бүрийн 6 дугаар сарын 10-ны дотор хүргүүлэх, Алсын хараа-2050 Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого шүүхийн хараат бус байдал хангагдаж, хариуцлагатай иргэн төвтэй шүүх тогтолцоо төлөвшинө гэж туссан. Улсын Их Хурлын 2024 оны 4 дүгээр сарын 25-ны өдөр нэгдсэн хуралдаанаар батлагдсан шүүх эрх мэдлийн хөгжлийн бодлого, зорилго, зорилтод хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд тохирсон, тогтвортой, урьдчилан тооцоолсон санхүүжилтийн тогтолцоог бүрдүүлнэ. Шүүхээс үйл ажиллагааг тасралтгүй явуулах эдийн засгийн баталгааг хангана гэж тус тус заасан байх тул 2025 оны Төсвийн хязгаарын саналыг боловсруулсан болно.

Монгол Улсын 2025 онд баримтлах тэргүүлэх бодлогын чиглэлд Монгол Улсын 2021-2025 онд хөгжүүлэх 5 жилийн үндсэн чиглэлд шүүх эрх мэдлийг улс төр, бизнесийн бүлгийн ашиг сонирхлоос ангид, хараат бус байлгаж, шүүх үйл ажиллагаанд шударга ёсыг тогтоож, иргэдийн итгэлийг сэргээж ажиллах бодлогын хүрээнд 2025 оны төсвийн хязгаарын саналыг боловсруулах зарчим баримтлав.

Шүүхийн ерөнхий зөвлөлийн 2024 оны батлагдсан төсөв 2025 оны төсвийн хязгаарын хүснэгтээр харуулсан зардлын ангиллаараа урсгал зардлын төсөв 2024 онд 145 тэрбум 675268.4 байсан бол 2025 онд 287 тэрбум 449846.6 гэж, хөрөнгө оруулалтын зардлын төсвийг 19 тэрбум 825 2024 онд байсан бол 2025 онд 143 тэрбум 863017.3 гэж. Нийт төсөв 2024 онд 165 тэрбум 500 сая 268.4 гэсэн бол 2025 онд 431 тэрбум 312 сая 863.9 гэж төсөвлөсөн.

Урсгал зардлын төсвийн хувьд цалин хөлс дээр нийт 2024 онд урсгал зардлын нийт дүн бол 145 тэрбум 675 сая 268.4 гэсэн бол 25 онд 287 тэрбум 449 сая 846.6 гэж.

Үндэслэлээ бол Улсын Их Хурлын 2016 оны 42 дугаар тогтоолоор 699 шүүгч байхаар баталсан ба уг орон тоонд үе шаттай хүргэх Байнгын хороонд чиглэл олгосон. Энэ хүрээндээ бид нар 2025 онд 650 шүүгч ажиллуулахаар цалингийн сангаа тусгасан.

Монгол Улсын шүүхийн тохиолдлын 46 дугаар зүйлийн 46.1-д шүүгчийн албан тушаалын цалингийн хэмжээнд эдийн засгийн хувьд бусдаас хараат бус ажиллах, амьдрахад хүрэлцээтэй, баталгаатай байх боломжийг хангасан байна гэж заасны дагуу шүүгчийн ажлын ачаалал, инфляцын түвшинтэй уялдуулан хийсэн судалгаагаар шүүгчийн үндсэн цалинг 5.7 саяд хүргэж нэмэгдүүлэх шаардлагатай гэсэн үр дүн гарсан.

Улсын Их Хурлын 2023 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн 117 дугаар тогтоолоор шүүгчийн үндсэн цалинг 4.7 сая төгрөг байхаар тогтоосон бөгөөд 2025 онд судалгаагаар гарсан үр дүнд тулгуурлан 5.7 сая төгрөг болгож нэмэгдүүлэх цалингийн санг тооцоолсон.

Монгол Улсын шүүхийн тухай хуулийн 46 дугаар зүйлийн 7 дахь хэсэг шүүгчийн ажлын ачаалалд тооцох шалгуур үзүүлэлт, шүүгчид нэмэгдэл урамшуулал олгох журмын журмыг Ерөнхий зөвлөл батална гэж заасны дагуу шүүгчид нэмэгдэл урамшуулал олгох журмыг Ерөнхий зөвлөл баталж, 2025 оны төсвийн төсөвт тусгасан.

Анхан болон давж заалдах шатын шүүхийн хянан шийдвэрлэж байгаа хэрэг маргааны статистик судалгаагаар хэрэг маргааны тоо сүүлийн жилүүдэд дунджаар 25 хувийн өсөлттэй

байгаагийн дээр олон оролцогчтой хэрэг маргааны тоо нэмэгдсэн.

2022 онд шүүхийн захиргааны ажилтны орон тоо 80, 2023 онд 73 онтойгоор нэмэгдүүлсэн бөгөөд сүүлийн жилүүдэд шүүхээр хянан шийдвэрлэж байж байгаа хэрэг, маргаан нэмэгдэж ажлын ачаалал ихэссэнтэй холбоотойгоор шүүгчийн туслах, шүүх хуралдааны нарийн бичиг, эвлэрүүлэн зуучлагч, эвлэрүүлэн зуучлагчийн туслах гэх мэт шүүхийн захиргааны албан хаагчдын орон тоог 317 тоогоор нэмэгдүүлэх гарцаагүй шаардлага үүссэн.

Хялбар ажиллагааны шүүх байгуулах тухай Улсын Их Хурлын шийдвэр гарсан. Үүнтэй холбогдуулаад шүүх шүүхийн захиргааны ажлын цалингийн сан 4.3 тэрбумыг төлөвлөсөн. Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 3 дугаар сарын 27-ны өдрийн 128 дугаар тогтоолын дагуу төрийн захиргааны болон үйлчилгээний албан тушаалын цалингийн хэмжээг нэмэгдүүлэн тооцсон. Орон нутаг дахь шүүхэд ажиллаж буй төрийн захиргааны болон төрийн үйлчилгээний ажилтанд орон нутгийн нэмэгдэл 20 хувийг олгохоор, сум дундын шүүхэд ажиллаж байгаа төрийн албан хаагчийн нэмэгдлийг 40 хувиар тооцоолсон. Мөн шүүгчийн зэрэг дэвийн нэмэгдлийг 13.5 тэрбумаар нэмэгдүүлсэн.

Ингээд нийгмийн даатгалын санд 12 тэрбум 336 сая 025 энэ бол 24 оных. Одоо бол 25 онд 18 тэрбум 621546.6 гэсэн энэ цалингийн сангийн өсөлттэйгөөр холбоотой НДШ-ийн зардал нэмэгдсэн.

Тогтмол зардал 2024 онд 4 тэрбум 147 сая 928.7 гэж байгаа. Үүнийгээ 2025 онд 11 тэрбум 359 сая 199 мянга 7 гэж. Монгол Улсын Шүүхийн тухай хуулийн 71 дүгээр зүйлийн 71.6-д шүүхийг хэвийн тасралтгүй ажиллах зохион байгуулалтын нөхцөлөөр хангах, 74.2-т шүүх шүүгчийн үйл ажиллагааг хараат бусаар явуулахад шаардагдах байр, иргэдийг хүлээн авах болон шүүх

хуралдааны танхимаар хангагдсан байхаар заасан бөгөөд гэрэл цахилгаан, халаалтын зардал тарифын өсөлтөөс хамааран ашиглалтын зардал өссөн. Нийслэлд үйл ажиллагаа явуулж байгаа анхан болон давж заалдахын шүүхүүд зориулалтын бус хуучирч муудсан, актлагдсан зай талбай хүрэлцээгүй, эрүүл ахуйн шаардлага хангахгүй байранд үйл ажиллагаа явуулж байгаа нь шүүхийн үйлчилгээг иргэдэд хүртээмжтэй хүргэх, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг хуулийн дагуу хуулийн хугацаанд явуулах нөхцөл алдагдахад хүргэж байгаа.

ЧД-ийн Эрүүгийн хэргийн анхан шатын шүүх, СБД-ийн Эрүүгийн хэргийн анхан шатын шүүх, ХУД-ийн Эрүүгийн хэргийн анхан шатын шүүх, БГД-ийн Эрүүгийн хэргийн анхан шатын шүүх, ЧД-ийн Иргэний хэргийн анхан шатын шүүх, БЗД-ийн анхан шатын шүүх, БГД, ХУД-ийн Иргэний хэргийн анхан шатын шүүх байр түрээсэлж үйл ажиллагаагаа явуулахаас өөр аргагүй нөхцөл байдалд байгаа тул шүүхүүдийн байрны түрээсийн зардалд 5 тэрбум төгрөг төсөвлөсөн.

Хялбар ажиллагааны шүүх байгуулах шийдвэр гарч байгаа. Уг шийдвэртэй холбогдуулаад шүүхэд зориулсан барилга баригдах хүртэл бол 4 мянган м² талбай бүхий түрээсийн байранд үйл ажиллагаа явуулах шаардлагатай тул 2.9 тэрбум төгрөгийн түрээсийн зардлыг төлөвлөсөн.

Хангамж, бараа материалын зардал 2024 онд 5 тэрбум 246 сая 644.9 төгрөг гэж, 2025 онд 7 тэрбум 15 сая 785.4 төгрөг гэж төлөвлөсөн. Үүний үндэслэл нь Монгол Улсын Шүүхийн тухай хуулийн 71 дүгээр зүйлийн 71.6-д шүүхийг хэвийн тасралтгүй ажиллах зохион байгуулалтын нөхцөлөөр хангах, мөн хуулийн 21.1 шүүх соёмбо, өөрийн нэр бүхий тамга тогтоосон загвараар үйлдсэн тэмдэгтэй байх бөгөөд албан бичгийн болон шүүхийн шийдвэрийн

хэвлэмэл хуудас хэрэглэх .../минут дуусав./

Д.Цогтбаатар: Энхбилиг даргаа жоохон товчилно шүү.

Л.Энхбилэг: За. Эдгээр үндэслэлүүдээр бол нийтдээ хангамж, бараа материал дээр ийм зардал тооцоолсон. Норматив зардал дээр бол 111 сая 656.8 гэж 24 онд төсөвлөснийг 279 сая 427.6 гэсэн энэ бол шинээр томилогдсон шүүгчийн нөмрөг авах, нормын хувцастай байх зэрэг материалтай.

Багаж техник хэрэгсэл дээр бол 2024 онд 2 тэрбум 841 сая 714.6 гэсэн бол 2025 онд 6 тэрбум 729 сая 300 мянга гэж. Үүний үндэслэл нь Шүүхийн тухай хуулийн 71.6, 74.1.3, 74.2, 71.1.14 гэсэн. Энэ нь өөрөө нөгөө Шүүхийн тухай хуулийн 49.6-д заасан шүүгч аюулгүй байдлаа хамгаалах зорилгоор бие хамгаалах тусгай хэрэгслийг эзэмших, биедээ авч явах техник хэрэгсэл гэсэн ийм зүйлүүдтэй холбоотой.

Тавилга. Энэ дээр бол 2024 онд 1 тэрбум 491 сая 555.6 сая гэсэн. 2025 онд 13 сая 13 тэрбум 7 сая 250 төгрөг гэсэн. Энэ дээр шүүх нийтдээ бол шүүх хуралдааны танхим 129 танхим байгаа. Үүнийг 91 танхимын сандал, ширээ чанарын шаардлага хангахгүй байгаа. Олон шинэчлээгүй шүүхийн үйл ажиллагаа иргэдийн тоо байнга өсөж байгаатай холбогдуулаад сүүлийн 11 жилд иргэдэд зориулсан сандал, ширээ, тавилга шүүх, шүүгчийн захиргааны ажилтны ширээ, сандал бол шинэчлэгдээгүй. Үүнийг шинэчлэх шаардлагатай байгаа юм.

Урсгал засвар. Үүн дээр 2024 онд 3 тэрбум 939 сая 437 төгрөг төлөвлөсөн. 2025 ондоо 4 тэрбум 86 саяыг төлөвлөж байна. Үүний хуулийн үндэс нь Шүүхийн тухай хуулийн 71.1.6, 74.1.3, 74.2 гээд.

Шүүх үйл ажиллагаанд өдөр тутам ашиглах тоног төхөөрөмж,

тээврийн хэрэгсэл хуучирч муудаж байгаатай холбоотой засвар үйлчилгээгээс урсгал засвар хийх шаардлагатай байгаа.

Томилолтын зардлын хувьд 2024 онд 890 сая 500 мянга гэсэн. 2025 онд 1 тэрбум 476 сая 738.2 сая гэж тооцоолсон. Үүний хуулийн үндэс нь бол дээрх хуулийн заалт, түүнчлэн шүүгч нар бол бүрэлдэхүүнд өөрийн харьяалах шүүхээсээ өөр бусад шүүгч рүү томилолтоор явдаг. Энэ нь орон тоо дутуу байгаатай холбоотой байгаа.

Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр 3 тэрбум 222477 саяыг бол 2024 онд төсөвлөж өгсөн. Үүнийг 5 тэрбум 596 сая 660 гэсэн. Үүний үндэслэл нь бол шүүх, шүүгчийн аюулгүй байдлыг хангах, шүүгчийн амь насны эрүүл мэндийн даатгалын үйлчилгээний төлбөртэй холбогдолтой байгаа.

Бараа, үйлчилгээний бусад зардал. Энэ нь өөрөө шүүгчийн орон тоо өсөж байгаатай бас холбоотой байгаа шүү. Энэ бусдаар гүйцэтгэх ажлын ажил үйлчилгээний төлбөр дээр. Бараа, үйлчилгээний бусад зардал дээр 1 тэрбум 259 сая 141.9 гэж 2024 онд төсөвлөж өгсөн. Одоо бид 2025 ондоо 10 тэрбум 991 сая 600 мянга гэж төлөвлөсөн. Энэ дээр бол шүүхийн захиргааны ажилтныг дадлагажуулах, мэргэшүүлэх, сургалттай холбоотой олон нийтэд шүүхийн нээлттэй, ил тод байдлыг сурталчлах, захиргааны албан хаагчдыг тогтвор суурьшилтай ажиллуулах энэ ажилтай холбоотойгоор 2025 онд авч хэрэгжүүлэх арга хэмжээ, мөн шүүхийн хөгжлийн бодлоготой холбогдсон 25 онд хийх хэрэгжүүлэх арга хэмжээний санхүүжилтэд 8.8 тэрбум гэж төлөвлөсөнтэй холбоотой юм.

Урсгал шилжүүлэх. Үүн дээр 2024 онд 11 тэрбум 5 сая 898 аравны гэж төлөвлөсөн бол одоо 2025 онд 45 тэрбум 643.8 гэж төлөвлөсөн. Үүнд бол шүүгчийн өндөр насны тэтгэвэр байгаа.

Мөн шүүгчийн 65 шүүгчийн 16.8 мянган төгрөг, энэ тэтгэмжтэй холбоотой.

Түүнчлэн захиргааны албан хаагчдын 5 жил тутам 6 сарын тэтгэмж, 2013 оны Шүүх байгуулах хуулиар томилогдоогүй 8 шүүгчийн тэтгэмж 2.7 гэж тусгагдсан байгаа.

2. Хөрөнгө оруулалт.

Хөрөнгө оруулалтын нийт дүн 2024 онд 19 тэрбум 825 сая байсан бол 2025 онд 143 тэрбум 863 сая 17.3 гэсэн. Энэ бол 11 байртай холбоотой.

Д.Цогтбаатар: Ер нь товчилъя. Яагаад гэвэл материал Энхбилиг дарга тарчихсан байгаа байхгүй юу. Тийм, тэгэхлээр гишүүд асуух юмнуудаа өөрсдөө асуугаад асуугаад, тэгээд та тайлбараа хэлээд явчих нь зөв байх. Тэгэх үү?

Л.Энхбилэг: Тэгье, ойлголоо.

Д.Цогтбаатар: Шүүхийн ерөнхий зөвлөлийн дарга Энхбилиг даргад баярлалаа

Улсын Их Хурлын Тамгын газрын Хяналт шалгалт, үнэлгээний газрын Төсвийн хяналт, шинжилгээний хэлтсээс Шүүхийн ерөнхий зөвлөлийн 2025 оны төсвийн төсөлд хийсэн дүн шинжилгээний талаарх танилцуулгыг сая хэлснээр бүгдэд нь хүргэчихсэн байгаа.

Шүүхийн ерөнхий зөвлөлийн 2025 оны төсвийн төслийн урсгал зардалтай холбогдуулан асуух асуулттай гишүүд нэрсээ өгнө үү.

Энх-амгалан гишүүнээр тасаллаа. Ж.Сүхбаатар гишүүний микрофоныг өгье.

Ж.Сүхбаатар: Энэ Улсын Их Хурлын Хууль зүйн байнгын хорооны энэ удаагийн парламентын сүүлийн хуралдаан л даа. Тэгээд яах вэ манай

Шүүхийн тухай хуулийг ажлын хэсгийнхэн бол ЧД, СБД-ийн Иргэний хэргийн шүүхтэй танилцаж байсан байна. Тэгээд тэр бол маш хүнд нөхцөлд л бөгс эргэх зайгүй юман дээр шүүгч л сууж л байсан л даа. Дээр нь сая би өөрөө бас ЧД-ийн Эрүүгийн хэргийн анхан шатын шүүх дээр ингээд л очиж үзэж байна шүү дээ хууль зүйн асуудал үүсээд. Тэгээд ЧД, СБД хоёр чинь нийлээд энэ чинь Монгол Улсын хүн амын 8, 9 хувь шүү дээ. Тэгээд хаа байсан БЗД дээр очиж ингээд л үйлчлүүлж байгаа байхгүй юу.

Тэгэхээр энэ та хэд ингээд маш их хэмжээний мөнгө нэмээд байдаг, үүнийг чинь ерөөсөө бид нар хөөцөлдөхгүй бол хэн ч ярихгүй юм байна. Тэгээд ЧД, СБД-ийн хүмүүс Баянзүрхийн тэр хаа. Баянзүрх чинь өөрөө дангаараа Монгол Улсын хүн амын 25 орчим хувь шүү дээ. Хэчнээн ядарсан байлаа гээд та нар мөнгө хэмнэлээ гээд тэр Баянзүрх дээр байдгаа ядаж болиулмаар байх юм. Энэ чинь СБД, Чингэлтэй хоёр чинь энэ Улаанбаатарын үндсэн дээ төв, бараг үндсэн Улаанбаатар чинь энэ шүү дээ. Энэ хоёр дүүрэг. Тэгээд энийгээ Цогтбаатар дарга ч гэсэн ингээд Хууль зүйн байнгын хорооны дарга СБД-ээс сонгогдсон, би ЧД-ээс сонгогдсон. Ингээд эрүүгийн хэргийн шүүх гэхэд та бид нарын чинь Сүхбаатар, Чингэлтэй дүүргийн шүүх рүү очиж байгаа хүмүүс бүгд БЗД рүү очдог.

Тэгээд чирэгддэг, тэгээд олон удаа хурал нь зарлагдана, хойшилно. Ингээд л явдаг. Тав тухгүй. Бараг энэ их шүүх хуралдаанд оролцож байгаа ч угаасаа одоогийн манай энэ систем тарчлаа юм байна лээ шүү дээ. Зарим хөөрхий хүмүүс бас хэлээд л байгаа нь үнэн л юм байна лээ. Яах вэ мань мэт улс төрч хүмүүс тийм юм нөгөө янз бүрийн зовлонгоо ил гарч ийм юм байна, тийм байна гэж хэлдэггүй л болохоос биш зүгээр л хүн тарчлан зовоох зориулалттайгаар бүх систем нь ингээд мөнгөгүй гэдэг нэрийн доор, эсвэл байгаа байдал нь энэ гэдэг нэрийг нь энэ доор.

Энийгээ ядаж энэ чинь өөрөө хүмүүсийг аягүй тийм хүнд байдалд ордог. Гадаа ингээд л багшилдаад л, тэгээд л тийшээ очих гэж байна гээд нөгөө шүүгчдээ загнуулчих вий гээд бараг нөгөө түгжрэлтэй үед чинь эрт явах ёстой байдаг. Тэгээд тэндээ юм очив уу үгүй юу нөгөөдөх нь хойшилчихно. Хойшлоод л буцаад л явах болдог.

Тэгэхээр ядаж энэ Чингэлтэй, СБД-ийнх нь тэр холбогдож байгаа хүмүүс нь тэнд тэр дүүргийнхээ энэ хоёр Сүхбаатар, Чингэлтэй хоёрынхоо дунд л баймаар юм. Энэ хавиар чинь оффис, орон байр зөндөө л байгаа шүү дээ уг нь. Тэгээд Баянзүрх дээр очихоор тэнд нь хямдхан юм таардаг юм уу эсвэл? Эсвэл энэ сэтгэл зүтгэл дутаад байдаг юм уу? Одоо бол тодорхой хэмжээнд бид зардлыг нэмж байна шүү дээ, нэмж байна. Нэмж байгаа юм бол байраа юу яачихмаар байх юм. Иингээд л шүүхийн хуралдаан зарлах гэхээр байхгүй хуралдаж багтахгүй. Цагдаагийн сүлд чуулга гээд л жишээлбэл ингээд тэнд байранд түрээсэлж өнөөдөр ингэж байна гээд л. Тэгээд нөгөө нь зах замбараа байхгүй. Хаана нь суух юм, яах юм, ийх юм бүү мэд.

Ер нь шүүхээр орно гэдэг бол орон байрнаасаа авхуулаад л хүмүүсийг яаж тав тухгүй байлгах вэ гэдэг тийм маягаар хийгдчихсэн. Эсвэл мөнгө байхгүй гэдэг нарийлдаг байдлаар ингэчихсэн. Гэтэл ер нь шүүх эрх мэдлийн энэ дорой байдал чинь өөрөө хүмүүсийн бухимдлыг хүргээд байгаа байхгүй юу. Тэгээд тэрийгээ дандаа шүүгчид нялзаадаг. Шүүхийн байр гэдэг бол шүүгчид зориулагдсан байр биш. Тэр шүүхээр олон зуун мянган хэрэг орж, гарч байна. Тэр болгонд олон зуун мянган иргэд үйлчлүүлж байна. Дүүргээр ярих юм бол олон арван мянган иргэд үйлчлүүлж байна.

Тэгэхээр та хэд маань л Шүүхийн ерөнхий зөвлөлөөс ингээд яасан Энхбилиг дарга байж байна. Шүүгчид та хэд маань л сэтгэл зүтгэл гаргахгүй бол энэ

улсад чинь өөр анхаарахгүй. Би тэгээд түрүүн хэлэх гэж байгаа нь Сүхбаатар, Чингэлтэйн Эрүүгийн хэргийн шүүх ядаж энэ Сүхбаатар, Чингэлтэй хоёрынхоо аль нэгэнд нь баймаар байна. Тэгээд ийм мөнгө зарж байж ядаж энийг шийдчих л дээ.

Би эндээс сонгогдсон гишүүний хувьд өмнө анхаарах ёстой байсан. Гэхдээ л би өмнө нь энэ Шүүхийн хуультай чинь төсвийг чинь ерөнхийд нь нэмээд л яваад байсан. Тэгээд энэ бол маш хүнд асуудал байна шүү. Тэрнээс Баянзүрхэд очиж үйлчлүүлдэггүй баймаар байна.

Д.Цогтбаатар: 4 дүгээр микрофон хариулъя.

Л.Энхбилэг: Тэгээд 2015 оноос хойш шүүхэд яг нэг байранд үйл ажиллагаа явуулаад байгаа юм. Тэгээд жил болгон хүн ам өсөж байна, хэрэг маргаан өсөж байна, шүүгчийн орон тоо нэмэгдэж байгаатай холбогдуулаад яг байрны асуудал өнөөдөр яг маш хэцүү хүнд байдалд орж байгаа.

Захиргааны албан хаагчид маань ч хүртэл нэг өрөөнд бөгс эргэх зайгүй, хэргээ ч тавих зайгүй тийм нөхцөл байдалд ажил хийж байгаа. Бид нар яг энэ байдлыг арилгахыг хүсэж төсвөө тавьсан.

Гэхдээ Шүүх байгуулах хуулиараа бол нийслэлд эрүү, иргэний дагнасан шүүх тойргийн зарчмаар байгуулагдаж байгаа. Үүнтэй холбогдуулж бид нар яг баруун, зүүн талд, хоёр талдаа дүүргийн анхан шатын иргэний шүүх, дүүргийн анхан шатын эрүүгийн шүүх гэсэн ийм дагнасан шүүхүүдийг байрлуулахаар байрныхаа асуудлыг бас төсөвлөөд, зураг төсвөө бэлэн байгаа.

ХУД-т бид нар тэр 10 жил царцчихсан байгаа барилгынхаа асуудлыг сая 2024 оны төсөвт 5 тэрбум төгрөг тавьж өгсөн учраас энэ ажлаа эхлүүлээд ингээд явж байгаа юм. Яг энэнтэй

адилхнаар үечилж энэ ингээд шүүхийг байртай, стандартын байртай болгохын төлөө бид нар зорьж ажиллаж байна. Энэний эхлэл бол энэ 2025 оны төсөвт байгаа юм шүү. Орон нутгаа ч гэсэн бид нар орхиогүй. Орон нутагт бас захиргааны байгууллагын байранд шүүх үйл ажиллагаа явж байна. Хууль шүүхийн тухай хуульд шүүх өөрийн гэсэн байртай, түүндээ бол үйл ажиллагаагаа явуулах ёстой гэсэн ийм хуулийн заалттай. Үүнийгээ хэрэгжүүлэхийн төлөө бол ажиллаж байна. Энэ дээр дэлгэрэнгүйгээр манай гүйцэтгэх нарийн бичгийн дарга бас хариулна. Яг төсөв мөнгөтэй яг нарийвчилсан хариултад.

Д.Цогтбаатар: 3 дугаар микрофон.

Б.Эрдэнэтулга: Хууль зүйн байнгын хорооны дарга, гишүүдэд энэ өдрийн мэндийг хүргэе.

Өнөөдрийн байдлаар нийтдээ 116 шүүх, 41 Тамгын газар байгаагаас үүнээс 48 шүүх гэсэн өөрийн байргүй байгаа. Сүхбаатар гишүүний түрүүний асуудаг асуудал дээр БЗД-ийн Эрүүгийн хэргийн байран дээр Сүхбаатар, Чингэлтэйн шүүх нэмэгдчихсэн, ачаалал ихтэй, шүүх хуралдааны танхим хүрэлцэхгүй гэсэн байдал дээр байгаад байгаа.

Үүн дээр бас Зөвлөлийн дарга хэлсэн баруун талдаа, бас зүүн талдаа бас цогцолбор барих гээд хичээж байгаа. Мөн энэ оны төсөв дээр Чингэлтэй, СБД-ийн Эрүүгийн хэргийн шүүхийг тусад нь гаргах гээд бас түрээсийн байрыг бас судалгаа хийгээд хөөцөлдөөд явж байгаа.

Мөн Чингэлтэй, СБД-ийн Иргэний хэргийн шүүх бол нэг дор бас түрээсийн байранд байдаг. Мөн бас энийг бас тусад нь түрээсийн байранд гаргах гээд ингээд судлаад явж байгаа. Ойлголоо биелүүлнэ гишүүнээ.

Д.Цогтбаатар: Энхбаяр гишүүний микрофоныг өгье.

Б.Энхбаяр: Мэдээж өмнөх онд нэлээн нэмсэн шүү дээ тээ? Өмнөх онтойгоо харьцуулахад аймаар нэмэгдсэн байна тээ? Яах вэ энийг ойлгож байна. 10 жил хөрөнгө оруулалт хийгдээгүй бие даасан институт гэдгээр нь би бол зарчмыг нь би бол их юм ярихгүй.

Шүүхийн барилгатай холбоотойгоор 105 тэрбумаар шүүхийн барилга төсөвлөсөн байна л даа. Эндээс яг зураг төсөв нь хийгдчихсэн, магадлангаар эцэслэгдчихсэн нь яг хэдэн тэрбум байна? Тухайлбал, энэ хялбар ажиллагааны шүүхийг хаана барихаар тооцоод газар авсан юм уу? Хялбар ажиллагааны шүүхийг ярьж байгаа шүү. Хаана барих гэж байгаа гэдгийг би нэгдүгээрт сонирхож байна.

Хоёрдугаарт бид нар чинь гэр бүлийн шүүх сая Шүүх байгуулах хуулиар байгуулчихсан. Нийслэл Улаанбаатар хотод Гэр бүл, хүүхдийн шүүх 2026 оноос ажиллана 27 оноос тээ? Тэгэхээр энэ Гэр бүл, хүүхдийн шүүхийг яаж шийдье гэж та хэд энэ төсөвтөө тооцож барьсан юм байна уу, байхгүй юу? Энэ төсвийн хүрээнд шийдэх асуудлууд ярьж байна. Сая Шүүх байгуулах хуулийг дагасан тогтоол дээр бол шүүхийн байруудын асуудлыг төр, хувийн хэвшлийн түншилээр шийдэх асуудлыг Улсын Их Хурлын тогтоолд оруулсан. Энэ төр, хувийн хэвшлийн түншилээр барих байранд гэж ямар байр тооцож байна? Энэ дээр тооцоо судалгаа байгаа юу гэсэн хоёр дахь асуулт байна.

Гурав дахь асуулт нь энэ байр дотор Архангайн шүүх явж байх юм. Энэ чинь 24 оны төсөв дээр чинь Архангайн шүүх шийдэгдчихсэн гээд хассан биз дээ Төсвийн байнгын хороон дээр? Архангайн шүүх явж байх юм. Дүүргийн эрүү, иргэний хялбар ажиллагааны шүүх, тойргийн шүүхийн барилга шинээр барих гээд энэ яг хаана барих гээд байна? СБД-ийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийг шинээр барихаар явж байна. Энэ хаана барих гэж байгаа вэ? Энэ ордны хойд талд байгаа байрыг нураах

гээд байна уу, яах гээд байна? Энэ чинь нийслэлийн өмч байгаа тээ? Шүүхийн захиргааны ажилтнууд нь нийслэлийн өмч юм байна лээ шүү дээ. Энийгээ ишийдсэн юм уу? Эсвэл тэр би яг нөгөө зураг төсөл нь бэлэн байдаг байгаа даа гэдэг талаас нь лавлаж асуугаад байгаа.

Д.Цогтбаатар: 3 дугаар микрофон.

Б.Эрдэнэтулга: Энхбаяр гишүүний асуултад хариулъя. Нийтдээ барилга дээр 104 тэрбум байгаа. Үүнээс яг зураг төсөвтэй нь 72 орчим тэрбум байгаа. Бусад нь бол давхар нэмэх гэсэн тийм зураг төсөвтэй. Хүчитгэх бүх зураг төсөл, инженерийн шугам зургууд гарчихсан ийм зургууд байгаа. Нийтдээ ингээд 104 тэрбум бүгдээрээ зураг төсөвтэй, байр талбайгаа нэмэх, хүчитгэх боломжоор ингээд хангагдсан. Ингээд төсөвтэй байгаа.

Д.Цогтбаатар: 4 дүгээр микрофон Энхбилиг дарга.

Л.Энхбилэг: Энхбаяр гишүүний асуултад хариулъя. Бид нар хялбар ажиллагааны шүүхийг бол одоо БЗД-ийн эрүүгийн хэргийн Баянзүрх, Сүхбаатар, ЧД-ийн эрүүгийн хэргийн анхан шатын шүүх байрлаж байгаа тэр газар бид нар хялбар ажиллагааны шүүхээ шинээр барьж өргөтгөл маягаар хийнэ гэсэн ийм төсөөлөлтэй байгаа юм. Дүүргийн шүүхүүд маань эрүү, иргэн гээд дагнаад тойрог болчхож байгаа учраас баруун талдаа бол нөгөө Хан-Уулын цогцолбор дээрээ 6 шүүхээ байрлуулах, зүүн талд газраа олчхож байгаад 6 шүүхээ шинээр стандартын барилгатай болох гээд ингээд төсөвлөөд явж байгаа юм.

Нийслэлийн иргэдийн хурал, Нийслэлийн Засаг даргад бид нар газар олгож өгөөч гэсэн хүсэлтүүдээ тавиад нийтдээ энд нийслэлд 4 шүүхийн газрын асуудлыг ишийдвэрлэж өгөөч гэдэг хүсэлтээ тавьчихсан явж байгаа.

Одоо Дээд шүүх Хангардь ордон руу нүүмэгц нь нийслэлийн эрүү, иргэний хоёр, давахын шүүх нэг байранд байрладаг. Тэрийг салгаж эрүү, иргэний, давж заалдахын шүүхээ тус тусад нь гаргаж байгаа.

Д.Цогтбаатар: 4 дүгээр микрофоныг гүйцээж өгье.

Л.Энхбилэг: Архангайн шүүхийн хувьд бол 2024 оны төсөв дээр явж байгаад хасагдчихсан юм. Тэгээд одоо эргүүлээд бид нар тавиулж байгаа юм. Энэ зарим шүүхүүд энэ байр давхарлах юм байгаа юм. Энэ СХД-ийнх шүү гишүүн ээ. Сүхбаатар биш СХД-ийн анхан шатны шүүхийн барилгын 824.3 сая төгрөгийн нөгөө хажуу талдаа 2 давхар өргөтгөлтэй. Тэр дээр нь 1 давхар нэмж тэгж давхар өргөтгөх гэсэн тийм төсөв явж байгаа юм. Эргүүлээд үүнийгээ бид нар нөгөө хялбар ажиллагааны шүүхээ Баянзүрх дээр байрлуулчихаад дараа дараагийн барилгууд маань баригдах хүртлээ бас ингээд тодорхой хугацаа орох учраас тэр рүүгээ шүүхүүдээ шилжүүлж ажиллуулах гээд. Яг энэ Шүүх байгуулах хуулиар бол тухайн шүүхүүдийг яг тэр дүүрэгт байрлана гээгүй Улаанбаатар хотод байрлана гэгчихсэн учраас одоо бид нар шүүхийнхээ байрыг барьтлаа түрээсийн байрыг тухайн шүүхүүдийгээ нэг дор ингэж байрлахаар тийм түрээсийн байруудыг хайж байна.

Д.Цогтбаатар: Энх-Амгалан гишүүний микрофоныг өгье.

Б.Энх-Амгалан: Шүүхийн тухай хууль гарсны нэг онцлог бол энэ шүүхийн шинэчлэлийн л асуудал байгаа юм. Тэгээд энэ шүүхийн салбарт энэ автомашиных нь 75 хувь ингээд ашиглалтаас гарчихсан, тоног төхөөрөмжийн 75 хувь нь хуучраад ингээд ашиглалтаас гарчихсан, 129 танхим байгаагийн 91 нь тавилгагүй болчихсон. Ширээ, сандал байхгүй. Тэгээд дээр нь энэ нөгөө программ хангамжийн шийдэл хийж цахим хавтаст хэрэг үүсгэх, кибер аюулгүй байдлаас

хамгаалах сервер, тоног төхөөрөмж авах гээд ингээд зардлууд яваад байгаа юм. Тэгээд би эд нарыг бүгдийг нь дэмжиж байгаа юм. Энэ явах ёстой гэж.

Би юу асуух гээд байна гэхээр энэ 104.7 тэрбум байна шүү дээ. Барилга байгууламж барина гээд. Энэ дээрээс Өмнөговь аймгийн шүүхийн Тамгын газрын барилгыг орон нутгийнхаа зардлаар хийж болдоггүй юм уу? Өмнөговь чинь улсаас татаас авдаггүй бас Монголын ганц үүц газар шүү дээ. Тэгээд энийгээ аваад энийгээ яг зайлшгүй хэрэгцээтэй байгаа тэр Сүхбаатар, ЧД-ийнхээ шүүхийн барилгыг барих ажилд зарж болохгүй юу? Нэг дэх асуудал. Би зардал шилжүүлэх тухай яриад л байна шүү дээ.

Хоёр дахь нь би юу яах гээд байна гэхээр зэрэг та бүгдийн энэ үйл ажиллагаа явуулах гээд баахан тоног төхөөрөмж энэ тэр тавьчихсан энэ юмнаас чинь явж байгаад та хэдийн төсөвлөсөн 420 тэрбумаас 412 болоод ингээд ороод ирж байна. Хэрвээ 420 болгоод ингээд тэрүүгээр нь ингээд батлаад явуулбал энэ дээр нэмэлт тэр шаардлагатай байгаа шүүхийн байрыг хийж болох юм уу? Эсвэл энэ бүх юмнуудаа ингээд аваад ингээд ажиллах бололцоо, боломж чинь хангагдах юм уу гэдэг ийм хоёр асуулт би асуух гээд байна. Энэ дээр тодорхой хариулаадхаач.

Д.Цогтбаатар: 3 дугаар микрофон.

Б.Эрдэнэтулга: Өмнөговь барилга дээр 104 тэрбум байгаа. Өмнөговь аймгийн шүүхийн Тамгын газрыг барина гээд 9.5 тэрбумыг бид нар бас яриад төсөвлөчихсөн байгаа. Шүүхийн байрыг үүн дээр бас аймгийн захиргаатай бас холбогдож байгаа. Шүүхийн Тамгын газрын даргаар дамжуулаад аймгийн захиргаатай холбогдоод энэ мөнгөний тодорхой зардлыг нь гаргах боломжтой эсэх байдлаар судалгаа хийсэн байгаа. Аймгийн захиргааны зүгээс төсвөө харж

байгаад энэ асуудлыг шийдэж өгнө гэсэн боловч яг өнөөдрийн байдлаар яг ингэнэ, тэгнэ гэсэн яг тоймтой хариу өгөөгүй учраас энэ дээр бас тийм байгаа.

Ерөнхийдөө аймгийн удирдлагын зүгээс энэ асуудлыг дэмжинэ л гэдэг тийм байр суурьтай байгаа боловч яг хэдэн төгрөг яана ийнэ гэсэн асуудал тодорхойгүй байгаа.

Хоёрдугаар асуулт. Нийтдээ манайх Шүүхийн ерөнхий зөвлөлийн зардлын даргын төсөв 431 тэрбумаар орж ирсэн байгаа. Хууль зүйн байнгын хорооны санхүүгийн энэ бас 412 гэхихсэн байгаа. Энэ маань өнөөдрийн байдлаар бид бүхэн бол бүх юмаа тултал нь ерөөсөө бараг бүсээ чангалах маягаар л 431 тэрбумаа төсөвлөсөн явж байгаа. Хэрвээ гишүүд маань бас энэ төсвийг батлаад өгчих юм бол өнөөдрийн бас Монгол Улсад өгөгдөж байгаа шүүх байргүй байх, шүүх тоног төхөөрөмжгүй байх, шүүх захиргааны ажилтнууд хэвийн үйл ажиллагаагаар хангагдах, шүүхийн тээврийн хэрэгсэл, шүүгч нарын аюулгүй байдлыг хангах, тээврийн хэрэгсэл болон бусад тоног төхөөрөмж гэсэн бүх асуудал өнөөдөр нэг мөр шийдэгдэх тийм бодлогын тийм томоохон өөрчлөлт гарна.

Яагаад гэвэл шүүхийн сүүлийн 10 жилийн хугацаанд ерөөсөө шүүх энэ эрх... хэрэгжүүлж байгаа салбарыг бүрэн орхигдуулсан учраас өнөөдрийн энэ төсөв гэдэг энэ тоо ингэж орж ирээд байгааг та бүхэн бас ойлгож үзээрэй.

Д.Цогтбаатар: Энх-Амгалан гишүүн тодруулъя.

Б.Энх-Амгалан: Би бас яг Сүхбаатар гишүүнтэй адилхан саналтай л байгаад байгаа юм л даа. Тэгээд яах вэ би та нарыг яаж байна гэхээр зэрэг төвөөс татаас авдаггүй, тэр орон нутгийн төсөв нь нэлээн өндөр байдаг дотоод асуудлуудаа ерөнхийдөө шийдчихсэн аймаг учраас Өмнөговийнхоо төсвийг Сүхбаатар, Чингэлтэйнхээ тэр

байрны төсөв рүүгээ шилжүүлчхээж болдоггүй юм уу гэж асуусан. Та бол шилжүүлж болохгүй л гэдэг юм хэлж байх шиг байна.

Хэрвээ 431-ээр чинь батлаад өгөх юм бол ядаж тэд нарын байрны асуудлыг л шийдэх бодитой юм хийж болохгүй юм уу? Тэр компьютер нь бол тэгээд шат дараатай хангагддаг юм байгаа биз гэсэн ийм л санал тавьсан юм л даа. Тэгээд та надад алинд нь ч хариулсангүй.

Хэрвээ одоо тэр байр нь шийдэгдэхгүй бол энийг яг 431 болгож бид нар 412-оос нь өсгөх хэрэг байна уу, үгүй юү? Ядаж нэг зургийг нь хийгээд суурийг нь хийгээд, ажлыг нь эхлүүлчихмээр байгаа байхгүй юу 25 онд. Тэр л талаар асуусан юм.

Д.Цогтбаатар: 4 дүгээр микрофон Энхбилиг даргын.

Л.Энхбилэг: Энх-Амгалан гишүүний саналтай нэг байна. Аль болохоор бид нар ачаалалтай байгаа энэ шүүхүүдийгээ маш богино хугацаанд ажлын байраар, шүүхийн байраар хангах, стандартын байраар хангахыг хичээж ажиллаж байна. Тэгээд энэ бүгд маань төсөв мөнгөтэй холбоотой учраас та бүхэн энийг бас ойлгоод энэ оны төсвийг бид нарын төсөвлөж өгснөөр шийдвэрлэж өгөхийг хичээнгүйлэн хүсэж байна.

Тэгээд хэрвээ төсөвлөөд өгөх юм бол бид нар өөрсдөө цаг хугацаатай уралдаж ажиллана. Боломжтой байгаа. Тэр дээр иргэдийн хурал маань газраа олоод өгчихвөл тэгээд л бид нар энэ жилдээ хундамаа ухаад л тэгээд л ажлаа эхэлнэ шүү дээ. Нэгдсэн зургууд байгаа байхгүй юу. Шүүхийн байрны стандарттай жишиг зураг байгаа юм. 60х69-ийн хэмжээтэй, 30х30-ийн хэмжээтэй тэр шүүхээсээ шалтгаалаад нийслэлд, аймагт, сум дундад гэсэн ийм 3 зураг байгаа юм.

Д.Цогтбаатар: Ингээд Шүүхийн ерөнхий зөвлөлийн төсөвтэй холбогдуулаад, урсгал зардалтай холбогдуулаад асуулт асуух гишүүд асуулт асууж, хариултаа авлаа.

Шүүхийн ерөнхий зөвлөлийн 2025 оны төсвийн төслийн хөрөнгө оруулалтын зардалтай холбогдуулаад асуулт асуух гишүүд нэрсээ өгнө үү.

Алга байна.

Шүүхийн ерөнхий зөвлөлийн 2025 оны төсвийн төслийн хөрөнгө оруулалтын зардалтай холбогдуулан гишүүд асуулт асууж дууслаа.

Шүүхийн ерөнхий зөвлөлийн 2025 оны төсвийн төслийн талаарх танилцуулгатай холбогдуулан үг хэлэх гишүүд нэрээ өгнө үү.

Байхгүй байна.

Асуулт, хариулт хамт явчихлаа гэж ойлгоё. Тэгвэл ингээд хэлэлцэж байгаа асуудалтай холбогдуулан саналтай гишүүд байна уу? Энэ төсөвтэй холбогдуулаад санал хэлэх гишүүд байгаа бол. Анхан тэр томъёоллоороо.

Байхгүй байна. Ингээд одоо санал хураая.

Шүүхийн ерөнхий зөвлөлийн 2025 оны төсвийн төслийн саналыг бууруулахгүйгээр төсвийн ерөнхийлөн захирагчид хүргүүлэхийг дэмжье гэсэн томъёоллоор. Тэгье, анхан.

Шүүхийн ерөнхий зөвлөлийн 2025 оны төсвийн төслийн саналыг бууруулахгүйгээр төсвийн ерөнхийлөн захирагчид хүргүүлэхийг дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя.

Гэхдээ би энэ протоколд оруулахаар бас дүнгийн танилцуулчихъя. Өргөн барьсан нь 420 тэрбум 800.6 сая

төгрөг гэсэн ийм төсөвтэй. Үүгээр бид нар санал хурааж байна.

Санал хураалт дэмжье гэсэн томъёоллоор.

54.5 хувиар санал дэмжигдлээ.

Ингээд анхан. Шүүхийн ерөнхий зөвлөлийн 2025 оны төсвийн төслийг хэлэлцэж дууслаа. Дараагийн асуудалдаа оръё.

Одоо Шүүхийн сахилгын хорооны 2025 оны төсвийн төслийн талаар хэлэлцье.

Хэлэлцэж байгаа асуудалтай холбогдуулан хуралдаанд оролцож байгаа албан тушаалтнуудыг танилцуулъя. Албан тушаалтнуудын нэр хаана байна? Танилцуулга, ингэе тэгвэл.

Шүүхийн сахилгын хорооны дарга Ц.Давхарбаяр, Шүүхийн сахилгын хорооны ажлын албаны дарга Д.Мөнхзориг, Шүүхийн сахилгын хорооны нягтлан бодогч Б.Ариунжаргал гэсэн бүрэлдэхүүнтэй ажлын хэсэг байна.

Материал тараачихсан байгаа. Тийм учраас танилцуулга уншуулахаа больё. Оруулж ирсэн төсөвтэй холбогдуулаад асуулт асуух гишүүд нэрсээ өгнө үү.

Алга байна.

Оруулж ирсэн төсөвтэй холбогдуулан санал хэлэх гишүүд байна уу?

Алга байна.

Тэгвэл шууд санал хураалт руугаа оръё.

Шүүхийн сахилгын хорооны 2025 оны төсвийн төслийн саналыг бууруулахгүйгээр төсвийн ерөнхийлөн захирагчид хүргүүлэхийг дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя.

Би гэхдээ протоколд оруулах үүднээс дүнг нь танилцуулчихъя. Дүнг нь хэд байлаа эдний? 6 тэрбум 481.4 сая гэсэн дүнтэй юм байна. Энэ томъёоллоор энэ саналыг дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя.

54.5 хувиар санал дэмжигдлээ.

Өнөөдрийн хуралдаан, манай Байнгын хорооны отгон хуралдаан байгаа.

Саяын дөрвөн байгууллагын төсвийн саналыг Хууль зүйн байнгын хороо хянасан талаарх албан бичгийг 2025 оны төсвийн хүрээний мэдэгдэл энэ долоо хоногт батлагдсаны дараа албажуулж, тухайн төсвийн ерөнхийлөн захирагчид тус тус хүргүүлэх болно.

Хуулийн хугацааны шаардлагыг хангаж бид өнөөдрийн төсвийн саналыг хянан хэлэлцлээ.

Ингээд өнөөдөр хэлэлцэх асуудал дууссан тул Хууль зүйн байнгын хорооны хуралдаан өндөрлөлөө.

17.38 цаг

ДУУНЫ БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ
ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ
БУУЛГАЖ ХЯНАСАН:
ШИНЖЭЭЧ Д.ОТГОНДЭЛГЭР